




ХАРТ НОЙРС ЛТД



**УЛААНБААТАР АУДИТ
КОРПОРАЦИ ХХК**

**МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ
ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА (МОУИТБС)
МОНГОЛ УЛСЫН ГУРАВ ДАХЬ УДААГИЙН БУЮУ
2008 ОНЫ НЭГТГЭЛИЙН ТАЙЛАН**



Улаанбаатар хот
2010 оны 6 дугаар сар

Энэхүү тайлан болон хавсралтууд нь санаачлагын зорилгын үүднээс зөвхөн МОҮИТБС-ын Үндэсний Зөвлөл болон Ажлын Хэсгийн хэрэгцээнд зориулагдсан ба өөр бусад талуудын зорилго, хэрэгцээнд чиглэгдээгүй болно.

АГУУЛГА

Товчлолууд ба Тодорхойлолтууд.....	4
1. ОРШИЛ.....	6
1.1. Зорилго.....	6
1.2. Хамрах хүрээ.....	6
1.3. Хязгаарлалтууд/Ажлын үзэл баримтлал.....	6
1.4. ОУИТБС-ын Нэгтгэлд оролцогч талууд.....	6
1.5. Тайлангийн бүтэц.....	7
1.6. Талархал.....	7
2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ.....	8
2.1 Санхүүгийн урсгал.....	8
2.2 Анхны урсгал.....	9
2.3 Залруулагдсан урсгал.....	9
2.4 Засгийн газрын харьяа яам, агентлагууд.....	9
2.5 Орон нутгийн засаг захиргаа.....	10
2.6 Материаллаг орлого.....	10
2.7 Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал.....	11
2.8 Аудитлагдсан санхүүгийн тайланд суурилсан мэдээлэл.....	11
2.9 Сэлэнгэ болон Дархан-Уул аймгуудад хийсэн талбарын томилолтын ажил.....	11
3. МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР.....	12
3.1. Эрдэс баялаг.....	12
3.2. Нүүрс.....	13
3.3. Газрын тос.....	14
4. ХАНДЛАГА.....	16
4.1 Үндсэн суурь ба материаллаг байдал.....	16
4.2 Хандлага ба арга.....	16
4.3 Ажлын чиглэл, хоорондын уялдаа.....	17
4.4 Аргачлал.....	18
4.5 Талуудын оролцооны схем.....	19
4.6 Хамрагдсан компаниуд.....	21
5. САНХҮҮГИЙН УРСГАЛЫН НЭГТГЭЛ.....	22
5.1 Анхлан тайлагнасан санхүүгийн нийт урсгал.....	22
5.2 Залруулга ба Нэгтгэлийн дараахи нийт санхүүгийн урсгал.....	23
6 ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНҮҮД.....	25
6.1 Нийт шийдэгдээгүй зөрүүнүүд.....	25

6.2	Татварууд.....	26
6.3	Төлбөрүүд	27
6.4	Хураамж, үйлчилгээний шимтгэлүүд	27
6.5	Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг.....	28
6.6	Хүлээн авагч засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд	28
6.7	ЗГ-ын байгууллагуудад өгсөн хандивууд.....	28
6.8	Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал.....	30
7.	ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНД ӨГСӨН ХАНДИВ ТУСЛАМЖУУД (аймаг, сумд)	31
7.1	Хандив тусламжийн зөрүүнүүдийн шалтгаан	31
7.2	Томилолтын тайлан	31
7.3	Нийтлэг дутагдал	34
8.	АСУУДЛУУД.....	34
8.1	Тайлан гаргахад хойрго ханддаг байдал.....	34
8.2	Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар.....	34
8.3	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр.....	35
8.4	ЗГ-ын гаргасан тайлан нь бүрэн бус байгаа талаар	35
8.5	Хураамж, үйлчилгээний шимтгэл	35
8.6	Бүртгэлийн ажилтны ур чадвар, чадавхи.....	36
8.7	Харилцаа холбооны бэрхшээл.....	36
9.	ЗӨВЛӨМЖҮҮД	37
10.	ХАВСРАЛТУУД.....	41
	Хавсралт А - Нэгтгэлийн дүнд үүссэн залруулгууд (1) – санхүүгийн урсгалаар.....	42
	Хавсралт Б - Нэгтгэлийн дүнд үүссэн залруулгууд (2) – компаниар	57
	Хавсралт В - Мэдээллийн эх сурвалжууд-Засгийн газрын байгууллагууд.....	234
	Хавсралт Г - Компаниудын жагсаалт	235
	Хавсралт Д - Удирдлагын хариуцлагын захидлыг ирүүлсэн байдал	237
	Хавсралт Е - Уулзаж, ярилцсан хүмүүс.....	239
	Хавсралт Ж - Оролцогч талууд	240
	Хавсралт З - Оролцогч талуудын мэдээлэл	241
	Хавсралт И - Анхны зөрүүнүүдийн хүснэгтүүд.....	249
	Хавсралт К - Нэгтгэлийн дүнд үүссэн цэвэр залруулганы хүснэгтүүд.....	257
	Хавсралт Л - Шийдэгдээгүй зөрүүнүүдийн хүснэгт.....	265

Товчлолууд ба Тодорхойлолтууд

АМГ	Ашигт малтмалын газар
АХ	Ажлын хэсэг (ОУИТБС)
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
Ам.доллар	Америкийн нэгдсэн улсын мөнгөн тэмдэгт доллар
АОУС	Нэгтгэлийн Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн нэгдсэн улс
БГД	Баянгол дүүрэг
БОА	Байгаль Орчны Алба
БОАЖЯ	Монгол улсын Байгаль орчин аялал жуулчлалын яам
БНГ	Байгалийн нөөцийн газар
БЗД	Баянзүрх дүүрэг
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГТГ	Газрын тосны газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар (нийслэл, аймаг, дүүрэг сум)
ЗГ	Монголын засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МОУИТБС	Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
МОУИТБСАА	Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын алба
МХАҮТ	Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим
МУУУА	Монголын уул уурхайн үндэсний ассоциаци
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НБОУХ	Нягтлан бодогчдын Олон Улсын Холбоо
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ОНЗЗ	Орон нутгийн засаг захиргаа
ОХУ	Оросын Холбооны Улс
УГЕГ	Улсын гаалийн ерөнхий газар
УТОХГ	Улсын төсвийн орлого хураалтын газар
ҮЗ	Үндэсний зөвлөл
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЯ	Монгол улсын Сангийн яам
СБД	Сүхбаатар дүүрэг
СЭЗХ	Санхүү, эдийн засгийн хэлтэс
ТӨХ	Төрийн өмчийн хороо
Төг.	Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭБЭХЯ	Эрдэс баялаг эрчим хүчний яам

Харт Нойрс Лтд
Мэргэшсэн Нягтлан бодогчид

The Old Coach House
Southern Road
Thame, Oxfordshire
OX9 2ED England

Tel: 44 01844 21 88 36
Fax: 44 08700 94 14 69
Website: www.hart-nurse.co.uk

Улаанбаатар Аудит
Корпораци ХХК

“Маргад Центр” Төвийн 4-р давхар,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо,
Их тойруу, Улаанбаатар хот
Монгол улс

Утас: 976-11-321844, 329430, 70110744
Факс: 976-11-321844
Вебсайт: www.ulaanbaatar-audit.mn

Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын
Санаачилгын Ажлын Хэсэгт
МОУИТБСАА
Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж,
Туушин компаний байр, 512 тоот

2010 оны 06 сарын 10-ны өдөр

Харт Нойрс Лтд ба Улаанбаатар Аудит Корпораци ХХК-ийн консерциум нь МОУИТБСАА-ны зүгээс МОУИТБС-ын 3 дахь удаагийн буюу 2008 оны Нэгтгэлийн ажлыг (“Гэрээт ажил”) хийхээр сонгогдон гэрээ байгуулсан билээ.

Энэхүү гэрээт ажил нь АОУС буюу зөвшилцсөн горимын дагуу гүйцэтгэх ажилтай уялдан Холбогдох Үйлчилгээний стандартын дагуу хийгдсэн болно. Гэрээт ажлын горимууд нь тайлан болон түүний хавсралтууд энэхүү тайланд хавсаргасан Ажлын Даалгаварт тусгагдсаны дагуу гүйцэтгэгдсэн.

Бид олж ажигласан зүйлсээ энэхүү тайлан, түүний хавсралтуудаар тайлагнасан. Учир нь: Гүйцэтгэсэн горимууд нь нэгтгэлийн болон шалгах ажлыг АОУС буюу Шалгах Ажлын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэх зорилго агуулаагүй бөгөөд бидний зүгээс энэхүү тайланд харуулсан тодорхой мэдээллүүд, тэдгээртэй холбогдох аливаа гүйлгээнүүдэд ямар нэгэн баталгаа өгөх үүрэггүй юм. Нэмэлт горимуудыг авч хэрэгжүүлсэн тохиолдолд магадгүй зарим зүйлсийг бид анхааралдаа аван та бүхэнд тайлагнах байсан.

Энэхүү тайлан нь Ажлын Даалгаварт тусгагдсан зүйлсийн хүрээнд зөвхөн Ажлын Хэсэг болон Үндэсний Зөвлөлд мэдээлэх зорилго агуулсан бөгөөд өөр бусад талуудад хүргэгдэх болон өөр бусад зорилго агуулаагүй болно.

Тус тайлан нь зөвхөн заагдсан зүйлсийн хүрээнд хийгдсэн бөгөөд аливаа нэгэн нэгжийг бүхлээр нь хамарсан санхүүгийн тайлангуудийн хүрээнд хийгдээгүй.

Харт Нойрс Лтд
Мэргэшсэн Нягтлан бодогчид

Улаанбаатар Аудит
Корпораци ХХК

1. ОРШИЛ

Энэхүү тайлан нь МОУИТБС-ын 3 дахь удаагийн буюу 2008 оны Нэгтгэлийн гэрээт ажлын эцсийн тайлан юм.

Энэхүү тайлан нь тухайн санаачлагын зорилгын үүднээс МОУИТБС-ын Үндэсний Зөвлөл болон Ажлын Хэсгийн хэрэгцээнд чиглэгдсэн ба өөр бусад талуудын зорилго, хэрэгцээнд чиглэгдээгүй билээ.

Тайлан нь доорхи хэсгүүдээс бүрдэнэ:

Хэсэг I – Тайлан

Хэсэг II – Хавсралтууд

1.1. Зорилго

Энэхүү Гэрээт ажлын зорилго нь Олон улсын ОУИТБСАА-наас гаргасан журмын дагуу Монгол Улсын уул уурхайн салбарын олон нийтэд ил тод, найдвартай байдлыг тодорхойлоход оршино. Эцэст нь, энэхүү Гэрээт ажил нь дүн шинжилгээ болон уул уурхайн салбарын 2008 онд хийгдсэн материаллаг төлөлтүүд болон орлогуудын нэгтгэл зэргийг багтаасан.

1.2. Хамрах хүрээ

Харт Нойрс Лтд ба Улаанбаатар Аудит Корпораци ХХК-ийн ("Зөвлөхүүд") консерциум нь Гэрээт ажлын Даалгаварт тусгагдсан ажил үүргүүдийг хийж гүйцэтгэхээр сонгогдсон. Энэхүү Ажлын Даалгаврын хуулбарыг Хавсралт 3 –д харуулсан.

1.3. Хязгаарлалтууд/Ажлын үзэл баримтлал

Энэхүү тайланд өөрөөр заагаагүй бол, нэгтгэл нь бэлэн мөнгө болон бэлэн бусаар хийгдсэн төлбөрүүдийг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу хийгдсэн.

Аливаа материаллаг дүн бүхий орлого эсвэл төлбөрүүд нь тайлангийн маягтанд бүртгэгдэлгүй орхигдсон тохиолдолд бидний ажил үүрэг тэднийг олж илрүүлэхэд хангалтгүй юм. Тиймээс аливаа орхигдсон материаллаг дүн бүхий орлого эсвэл төлбөрүүд нь манай тайланд хамрагдахгүй болно.

Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ бид оролцогч талуудаас ирүүлсэн мэдээ мэдээлэл, тайлбарууд дээр тулгуурласан. Эдгээр мэдээллүүдийн нягт нямбай байдал болон бүрэн гүйцэд байдалд аливаа нэгэн нотолгоо хийгдээгүй болно.

Энэхүү тайланг Англи, Монгол хэл дээр бэлтгэсэн. Англи, Монгол хувиудын хооронд зөрүүтэй эсвэл зөрчилтэй зүйл гарсан тохиолдолд Англи хувийг баримтлана.

Манай тайланд 2010 оны 5 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх буюу УТЕГ –аас ОУИТБС-ын Ажлын Хэсэгт бидний анхлан танилцуулсан урьдчилсан тайлангийн байдалтай уялдуулан тогтоосон өдөр хүртэлх хугацаанд хүлээн авсан мэдээллүүдийг нэгтгэн оруулсан болно. Энэ өдрөөс хойш хүлээн авсан мэдээллүүдийг энэхүү тайланд оруулаагүй болно.

1.4. ОУИТБС-ын Нэгтгэлд оролцогч талууд

Сангийн Яам нь Засгийн газрын харъяа яам, агентлагуудаас ирүүлсэн мэдээллийг ОУИТБС-ын маягтын дагуу бэлтгэн гаргаж өгсөн. МОУИТБС-ын 3 дахь удаагийн буюу 2008 оны Нэгтгэлд оролцсон Засгийн газрын харъяа яам, агентлагуудын нэрсийг дор харуулав. Үүнд:

- Сангийн Яам
- Үндэсний татварын ерөнхий газар

- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
- Ашигт малтмалын газар
- Газрын тосны газар
- Гаалийн ерөнхий газар
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
- Төрийн өмчийн хороо.

Түүнчлэн, доор дурьдсан нийслэл, аймаг, дүүрэг сумдын засаг даргын тамгын газрууд өөрсдийн мэдээллийг ирүүлсэн. Оролцогч талуудын нэрсийн жагсаалтыг Хавсралт Ж-д харуулсан болно.

Энэхүү нэгтгэлд улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээрээ 100 сая төгрөгөөс дээш хэмжээний татвар, төлбөр, хураамжийг төлсөн олборлох үйлдвэрлэл эрхэлдэг 46 компани оролцсон.

Хамрагдсан компаниудын нэрсийн жагсаалтыг Хавсралт Г-д харуулсан болно.

1.5. Тайлангийн бүтэц

Энэхүү тайлан нь дараахи бүтэцтэй:

- а. Гүйцэтгэлийн хураангуй
- б. Монголын олборлох үйлдвэрлэлийн талаар
- в. Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ашигласан бидний хандлага
- г. Тайлагнан ирүүлсэн урсгалын (төлбөрүүд болон орлого) нийт дүн
 - i. МОУИТБСАА-д анхлан ирүүлсэн дүн
 - ii. Гэрээт ажлын хүрээнд хамаарахгүй зүйлсийг салган харуулсан дүн
 - iii. Анхны зөрүүнүүдийг нэгтгэсний дараахи байдлаарх дүн. Үүнийг хамрагдсан компаниудаас ирүүлсэн мэдээлэл болон тайлбарууд дээр суурилан хийх боломжтой байсны дагуу хийсэн.
- д. Шийдэгдээгүй зөрүүнүүдийн дүнг төлбөр, орлогын төрөл тэдгээрийн тухай мэдээлэл болон тайлагнасан дүнгүүд нь нэгтгэгдэн шийдэгдээгүй үлдсэн компаниудын нэрсийн хамт харуулсан байдал
- е. Талбарын томилолтын ажлын үр дүн болон аймаг сумдад хийгдсэн төлбөрүүдийн талаар
- ё. Гэрээт ажлын явцад ажиглагдсан асуудлуудын нэгтгэл
- ж. ОУИТБС-ын процесс болон ил тод байдлын үйл ажиллагааг сайжруулахад зориулан өгч буй зөвлөмжүүд

Анхны зөрүүнүүд, хийгдсэн залруулгууд болон шийдэгдээгүй зөрүүнүүдийн дэлгэрэнгүйг компани болон санхүүгийн урсгалын төрлөөр нь шинжилсэн ба эдгээрийг Хавсралтууд болон холбогдох анхан шатны баримтуудын хамт харуулсан.

1.6. Талархал

Засгийн газрын харьяа байгууллагуудын болон уул, уурхайн компаниудын гол албан тушаалтнуудтай уулзах, тэдэнтэй холбоо тогтоох, холбогдох газруудад захидал явуулах, хүлээн авах зэрэгт дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монголын ОУИТБСАА-ны хамт олон, Ш. Цолмон, Т. Хүрэлчимэг нарт Харт Нойрс Лтд болон Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хамтарсан консерциумын хамт олон чин сэтгэлийн талархал илэрхийлэхийг хүсч байна.

Мөн Засгийн газрын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас ирүүлэх мэдээллийн хариуг түргэвчлэх ажилд дэмжлэг үзүүлсэн Ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгор, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа нарт гүн талархал илэрхийлж байна.

2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Энэхүү бүлэгт 2008 оны МОУИТБС-ын Нэгтгэлд хамрагдсан компаниудаас хүлээн авсан ЗГ-ын тайлагнасан орлого болон компаниудын зүгээс төлсөн дүнгээ тайлагнасан байдал хоорондын нэгтгэлийн Гэрээт ажлын явцад ажиглагдан илрүүлсэн зүйлсийг нэгтгэн харуулсан.

2.1 Санхүүгийн урсгал

Доорхи хүснэгт нь дараахи зүйлсийг харуулна:

- Хамрагдсан компаниудын нийт урсгал болон ЗГ-ын хүлээн авсан дүн, компаниудын төлсөн дүн хоорондын зөрүүнүүдийн нийт дүн
- Нэгтгэлийн ажлын үр дүн хийгдсэн залруулгууд
- Нийт залруулагдсан болон шийдэгдээгүй зөрүүнүүдийн дүн.

Компаниас орон нутгийн засаг захиргаанд төлсөн татвар, төлбөр, хураамж	Засгийн газар	Компани	Анхны зөрүү мян.төг	Залруулга		Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүү мян.төг
				Засгийн газар	Компани	Засгийн газар	Компани	
Татварууд	513,176,775	529,354,346	(16,177,571)	821,835	(15,428,524)	513,998,609	513,925,821	72,788
Төлбөрүүд	117,144,724	118,715,936	(1,571,212)	(11,678,010)	(13,172,267)	105,466,713	105,543,670	(76,955)
Хураамж, үйлчилгээний шимтгэлүүд	2,434,776	2,918,513	(483,737)	52,050	(74,897)	2,486,826	2,843,616	(356,790)
Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	27,349,905	21,133,422	6,216,483	-	6,216,483	27,349,905	27,349,905	-
Хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд	-	26,669,948	(26,669,948)	26,669,948	-	26,669,948	26,669,948	-
Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандивууд	1,048,225	10,364,538	(9,316,313)	4,893,179	(4,353,078)	5,941,404	6,011,460	(70,056)
Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	4,580,546	3,727,118	853,428	(1,540,781)	(17,960)	3,039,765	3,709,159	(669,394)
Нийт	665,734,951	712,883,821	(47,148,870)	19,218,221	(26,830,242)	684,953,171	686,053,578	(1,100,407)

Байгаль хамгаалахтай холбогдон гарсан зардлууд нь ЗГ-т мөнгөөр төлөгдсөн урсгал биш бөгөөд үүссэн зөрүүг залруулах боломжгүй нь нэгтгэл хийх явцад тодорхой болсон тул нийт шийдэгдээгүй зөрүүнээс хасаж тооцвол эцсийн байдлаарх шийдэгдээгүй зөрүү дараах байдалтай байна.

Компаниас орон нутгийн засаг захиргаанд төлсөн татвар, төлбөр, хураамж	Шийдэгдээгүй зөрүү мян.төг	Залруулга	Эцсийн байдлаар шийдэгдээгүй зөрүү мян.төг
Татварууд	72,789		72,789
Төлбөрүүд	(76,956)		(76,956)
Хураамж, үйлчилгээний шимтгэлүүд	(356,790)		(356,790)
Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-		-
Хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд	-		-
Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандивууд	(70,056)		(70,056)
Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	(669,394)	679,511	10,117
Нийт	(1,100,407)	679,511	(420,896)

Байгаль хамгаалахтай холбоотой зардлууд ямар компаниуд дээр гарсан, зөрүү хэрхэн үүссэн гэдгийг харуулахын тулд цаашид энэхүү тайлан болон хавсралтуудад шийдэгдээгүй зөрүүг 1,1 тэрбум төгрөгөөр нь дэлгэрүүлэн тайлбарласан болно.

Байгаль хамгаалах зардалтай холбоотой асуудлуудын талаар Бүлэг 8.2-т, хэрхэн шийдэх зөвлөмжийн талаар Бүлэг 9.2 (г)-ээс үзнэ үү.

2.2 Анхны урсгал

МОУИТБС-д ирүүлсэн маягтууд нь доорх зүйлсийн уялдааны улмаас илт мэдэгдэм алдаатай байсан:

- i. Засгийн газрын харъяа, яам агенлагууд болон компаниуд нь шаардлагын талаар бүрэн дүүрэн ойлголтгүй
- ii. Маягтыг бэлтгэхдээ хайхрамж, тоомжиргүй байдлаар ханддаг, ялангуяа, УТЕГ нь өөрийн маягтыг ирүүлэхдээ дутуу дулимаг байдлаар хандсан
- iii. Шаардсан мэдээллийг ирүүлэхгүй байх, голчлон аймаг, сумдаас ирүүлэхгүй байх.

2.3 Залруулагдсан урсгал

Нэгтгэлийн ажлын дараа нийт шийдэгдээгүй зөрүү 1.1 тэрбум төгрөг болсон бөгөөд энэ нь оролцогч талуудаас өөр өөр тоо ирүүлсний улмаас шийдэгдэхгүй үлдэж байна. Энэхүү зөрүү нь ЗГ-ын нийт урсгалын 0.16%-г эзэлж байгаа билээ. Энэхүү дүн нь ОУИТБС-ын нэгтгэлийн ажлын хувьд материаллаг бүс байгаа хэдий ч Ажлын Хэсгийн зүгээс цаашид шалгаж үзэх шаардлагатай эсэхийг шийдвэрлэх хэрэгтэй.

Дээрх шийдэгдээгүй зөрүү нь ихэнхдээ орон нутгийн засаг захиргааны хүлээн авсан бага дүнтэй орлогуудаас үүсч байна. Ялангуяа Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс (357 сая төгрөг) болон Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал (680 сая төгрөг) зэргээс бүрдэж байгаа.

2.4 Засгийн газрын харъяа яам, агентлагууд

Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний Газар болон УТЕГ-ын холбогдох ажилтнууд биднийг мэдээллээр хангах тал дээр удаашралтай хандаж, манай багийн зүгээс олон дахин шаардуулж, цаг хугацаа алдуулж, ихээхэн чирэгдэл учруулж байлаа.

Яам, агентлаг хоорондын мэдээлэл солилцооны байдал, тэдгээрийн хоорондын харилцаа холбоог сайжруулах хэрэгтэй байна. Энэхүү хүндрэлийн улмаас ихэвчлэн ЗГ-ын зүгээс тоог орхигдуулан тайлагнах явдал ихээхэн гарсан байсан. Мөн УТЕГ-ын орон нутаг дахь хэсгүүдийн хоорондын уялдаа холбоо, мэдээллийг авах, тэдгээрийг төвлөрүүлэх байдлыг сайжруулах хэрэгтэй.

УТЕГ-ын систем болон үйл ажиллагааны явцыг хянан үзэж сайжруулах нь зүйтэй. Анхлан тайлагнагдсан дүнд хийгдсэн хэд хэдэн залруулгууд нь УТЕГ-аас ирүүлсэн дүн нь илт буруу зөрүүтэй тайлагнагдсаны улмаас хийгдсэн.

Тухайлбал, УТЕГ нь нэгэн компанийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ("роялти төлбөр")-ийн хүлээн авсан нийт дүнг 7.35 тэрбум төгрөг хэмээн тайлагнасан нь компанийн тайлагнасан дүнгээс 3.38 тэрбум төгрөгөөр бага байсан. УТЕГ-аас сүүлд нь ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу нийт дүн нь 10.73 тэрбум төгрөг буюу компанийн тайлагнасан дүнтэй адил ирсэн. УТЕГ нь энэхүү анхлан ирүүлсэн дүн болон дэлгэрэнгүй мэдээлэл хооронд гарсан зөрүүгийн шалтгаан буюу анхлан тайлагнагдаагүй үлдсэн байдлыг бүрэн дүүрэн тайлбарлаж чадаагүй.

2.5 Орон нутгийн засаг захиргаа

Аймаг, сумдын албан тушаалтангуудаас мэдээлэл авах үед өмнөх жилүүдэд гарч байсан хүндрэлүүд мөн давтагдаж байсан ба ялангуяа, хандив тусламжийн хувьд анхлан тайлагнагдсан 1.0 тэрбум төгрөг нь нэгтгэлийн явцад 4.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

Орон нутгийн засаг захиргаанаас ирүүлсэн тоон дүнгүүдэд голлох хоёр өөрчлөлт болон бусад жижиг өөрчлөлтүүд хийгдсэн:

- i. “Чин Хуа МАК Нарийн Сүхайд” ХХК-ийн ЗГ-ын дүнг компанийн анхлан мэдээлсэн дүнтэй харьцуулсны дараа 3.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн. Компанийн зүгээс нийт хандив, тусламжийн дүнгээ баталгаажуулсан дэлгэрэнгүй мэдээллээ ирүүлсэн ба үүндээ Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Соёлын Төвийн засварын ажил болон Шивээ Овоо хилийн боомтын зам барилгын ажилд оруулсан гэдгээ нотлон харуулсан. Бидний зүгээс энэхүү компаний тайлагнасан хандив, тусламжийн дүнг батлан харах үүднээс Өмнөговь аймгийн Гурвантэс сумын ЗДТГ-д албан бичиг илгээсэн. Гурвантэс сумын Соёлын Төвийн зүгээс дээрх хандив, тусламжийг авснаа нотлон баталсан бол Өмнөговь аймгийн Хөгжил, Бодлогын Хэлтсийн зүгээс хилийн зурвас хүртэл хийгдсэн зам барилгын ажлын зарцуулалт нь тодорхойгүй байгаа гэж хариу ирүүлсэн.
- ii. Бас нэгэн компани Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол, Түнхэл сумдын Тогтвортой Хөгжлийн Санд өгсөн хандив, тусламжийн дүн болох 1.0 тэрбум төгрөгийг тайлагнан ирүүлсэн байсныг ЗГ анхлан огт тайлагнаагүй байсан. Манай гэрээт ажлын багийн гишүүн талбарын томилолтын ажлаар газар дээр нь очин эдгээр сумдаар явж ажиллахад дээрх 1.0 тэрбум төгрөг нь бүртгэгдсэн байсныг олж илрүүлсэн.

Аймаг сумдын түвшинд тайлагнах үйл явц болон орлого ба зарцуулалтын бүртгэл, хяналтын үйл ажиллагааг шалгах хэрэгтэй ба ингэснээр ЗГ нь орлого нь бүрэн бүртгэгдсэн, зарцуулалт нь зүй зохистой явагдсан гэдгийг төсвийн төвшинд хяналттай байлгаж чадна.

Аймаг сумдаас ирсэн тоон дүнгүүдийг СЯ хүлээн авч нэгтгэдэг ба ингэхдээ аливаа нэгэн нотлох баримтыг авч хавсаргадаггүй байдал нь зөрүү чухам хаана үүссэн, өөрөөр хэлбэл, орон нутгийн түвшинд үү эсвэл СЯ-ны нэгтгэлийн үед үүссэн болохыг тодруулах боломжгүй болгож байлаа.

2.6 Материаллаг орлого

Ажлын Хэсгийн зүгээс 2008 оны Нэгтгэлд зориулан ЗГ-ын хүлээн авсан дүнгийн хувьд материаллаг байдлыг тодорхойлж, улмаар хамрагдсан байгууллагуудын бэлтгэх маягтанд тусгаж өгсөн. Бидний ажил тэрхүү батлагдсан тодорхойлолтын хүрээнд хийгдсэн.

Нэгтгэлийн хамрах хүрээ нь ирээдүйг харсан хянан шалгалтыг шаардаж байдаг. Учир нь: Бид материаллаг орлогыг оруулахгүйгээр хасах нь зүйтэй байсан байх гэж итгэж байна. Одоогоор багтаан оруулсан зарим орлогууд нь үнэндээ олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон ЗГ хоорондын урсгал бус, мөн зарим урсгалууд нь санхүүгийн хувьд тийм ч материаллаг бус байгаа билээ.

i. Дэд гүйцэтгэгчид

Уул уурхайн компаниудын олонхи нь өөрсдийн үйл ажиллагааны зарим хэсгийг бусад компаниудад дэд гэрээгээр даалган гүйцэтгүүлдэг. Хэрвээ эдгээр дэд гүйцэтгэгч компаниудаас хийсэн төлбөрүүдийг тус уул уурхайн компани нь төлсөн бол ОУИТБС-ын маягтанд багтаах хэрэгтэй.

Тиймээс, хэрвээ эдгээр дэд гүйцэтгэгч компаниудын төлбөрүүд нь материаллаг бол цааш цаашдын нэгтгэлийн ажлын хамрах хүрээнд тусгагдан орох шаардлагатай хэмээн бидний зүгээс зөвлөж байна.

ii. Хандив тусламж

Компаниудын тайлагнан ирүүлсэн хандив тусламжийн дүнгүүд нь ихэнх тохиолдолд ЗГ-т өгсөн бус харин сайн дурын болон нийгэм, олон нийтийн ашиг тусын (барилга, засвар гэх мэт) түлд өгсөн зардлуудыг харуулж байгаа билээ.

Тиймээс засгийн газарт төлөөгүй буюу өгөөгүй дүнг ОУИТБС-ын маягтны Хамрах хүрээ 2 буюу Ашиг орлогын урсгал хэсэгт оруулах нь зүйтэй хэмээн зөвлөж байна. Түүнчлэн, Ажлын Хэсэг нь ЗГ-т тайлагнах хандив, тусламжийн дүнгийн хамгийн бага дүнг тогтоох буюу анхааран үзэх хэрэгтэй.

iii. Хураамж, үйлчилгээний шимтгэл

Нийт залруулагдсан 685 тэрбум төгрөгийн 2.5 тэрбум төгрөг нь Засгийн газрын 2008 оны хувьд тайлагнасан хураамж, үйлчилгээний шимтгэл юм. Энэ нь ОУИТБС-ын нэгтгэлийн гэрээт ажлын хүрээнд хамрагдсан ЗГ-ын хүлээн авсан нийт орлогын зөвхөн 0.36% эзэлж байгаа юм. Тиймээс, Ажлын Хэсэг нь үүнийг цаашид оруулах эсэх тал дээр анхаарах шаардлагатай, учир нь, эдгээр нь санхүүгийн хувьд олборлох салбарын зүгээс оруулж буй материаллаг бус орлого юм.

2.7 Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал

Эдгээр зардлууд нь компаниудын зүгээс тайлагнагдсан хэдий ч ЗГ-ын байгууллагуудад төлөгдөөгүй, харин орон нутгийн гэрээлэгч талуудад төрөл бүрийн ажил гүйцэтгэсний хувьд төлөгдсөн. Тиймээс доорх байдлуудын улмаас ямар нэгэн нэгтгэл хийгдэх нөхцөл үүсэхгүй байна.

- а. Компанийн зүгээс СЯ болон ОУИТБС-ын зөвлөх нарт ирүүлсэн зардлын дүн;
- б. ЗГ нь компаниудын ирүүлсэн дүнд үндэслэн хийсэн болохоос яг бодитоор хүлээж авсан дүндээ үндэслээгүй болно.

Энэ нь хараат бус нэгтгэл болж чадахгүй байгаа юм. Тиймээс, эдгээр зардлуудыг нэгтгэх бус харин ОУИТБС-ын маягтны Хамрах хүрээ 2 буюу Ашиг орлогын урсгал хэсэгт оруулах нь зүйтэй хэмээн зөвлөж байна. Нийт шийдэгдээгүй зөрүүнүүдийн 2/3-г энэ төрлийн зардал эзэлж байгаа билээ.

БОАЖЯ-нд компаниудаас жил бүр ирүүлдэг "Байгаль Орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"-гийн зарцуулалтын дүнгүүд нь компанийн санхүүгийн ажилтан болон санхүүгийн мэдээлэлтэй холбоогүй техникийн талын ажилтангаар бэлтгэгдсэн болохыг бид ажигласан. Тиймээс ЗГ-т тайлагнасан зардал нь яг компанийн зардлын бүртгэлийн баримт мэдээтэй уялдаагүйгаар тайлагнагдсан байгаа юм. Цаашид, нэгэнт эдгээр тайлангууд нь компанийн зүгээс хийх ёстой байгаль орчны зарцуулалтын бодит байдалд хяналт тавихад үндсэн суурь болдог тул БОАЖЯ-ны зүгээс цаашид шалгалтыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

2.8 Аудитлагдсан санхүүгийн тайланд суурилсан мэдээлэл

Ажлын даалгаварт тусгагдсан ажил үүргүүд дээр нэмэлт болгож бид Удирдлагын хариуцлагын захидлыг бэлтгэн компани бүрийн Захирлуудын зөвлөлд илгээж, тайлагнасан мэдээлэл нь компанийн аудиторoor хянагдсан эсэхийг баталгаажуулахыг зорьсон. Учир нь, гэрээт ажлын эхний үе шатанд Маягт №1 нь компани бүрийн аудитораар хянан шалгагдаагүй болохыг бид ажигласан билээ. Нийт 46 компаниас 18 нь удирдлагын хариуцлагын захидалд хариу ирүүлсэн ба үлдсэн 28 компани нь хариу ирүүлээгүй. Энэ тухай дэлгэрэнгүйг энэхүү тайлангийн Хавсралт Д-д харуулсан.

2.9 Сэлэнгэ болон Дархан-Уул аймгуудад хийсэн талбарын томилолтын ажил

Орон нутгийн засаг захиргаанаас мэдээлэл авахад үүссэн хүндрэлтэй холбогдуулан ажлаа үр дүнтэй явуулах үүднээс бид 8 компаниас 2 аймгийн 6 сум, тосгон, 35 аж ахуйн нэгжүүд хамруулан талбарын ажлыг хийсэн. Энэ талаарх дэлгэрэнгүйг Бүлэг 7-д харуулсан.

3. МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР

Монгол улс нь байгалийн баялгийн хувьд ихээхэн нөөцтэй ба ялангуяа, алт, зэс, нүүрс болон бусад ховор байгалийн эрдэс баялагуудтай. Алт болон зэсний орд нөөцөөрөө дэлхийн томоохон нөөцүүдэд тооцогддог.

Өнөөдөр Монголын уул уурхайн салбар 42 мянга гаруй (буюу нийт ажиллах хүчний 4%) хүнийг ажлын байраар хангаж, Монгол улсын экспортын нийт орлогын 75%-ийг бүрдүүлж байна.

Эдийн засагт олборлох үйлдвэрлэлийн үзүүлж буй нөлөө дараахи байдалтай байна:

	2004	2005	2006	2007	2008
Дотоодын нийт бүтээгдэхүүний хувьд	17.3%	18,0%	30.0%	27,5 %	28.2%
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хувьд	64.7%	65,5%	68,4%	67.8%	64.3%
Экспортын нийт бүтээгдэхүүний хувьд	70.80%	75.8%	76,0%	68,8%	80.7%

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар

Уул уурхайн үйлдвэрлэлээс гадна газрын тос олборлолтын талаар дор тайлбарлалаа.

3.1. Эрдэс баялаг

Монгол улс нь алт, зэс, нүүрс, жонш, төмрийн хүдэр болон вольфрамыг үйлдвэрлэдэг ба эдгээрийн бараг дийлэнх болох зэсийн баяжмал, молибдени, нүүрс болон цайрыг БНХАУ, жоншийг ОХУ, АНУ болон Украин улсуудад мөн алтыг Канад, АНУ, Англи болон БНХАУ улсуудад экспортолж байна.

Монголын АМГ-аас ашиглах болон хайгуул хийх боломжтой нөөцүүдийн талаарх мэдээллийг дараахи байдлаар нэгтгэн гаргадаг:

Монголын байгалийн нөөц

Natural resources	Number of deposits
Gold	511
Copper	6
Molybdenum	3
Lead	4
Zinc	4
Tin	12
Tungsten	17
Iron	29
Coal	85
Fluorite	83
Limestone	48
Clay	81
Sand and gravel	84
Sand for construction materials	53

Уул уурхайн үйлдвэрлэл /бүтээгдэхүүнээр/


[мян.тонн]

	2004	2005	2006	2007	2008	2009
Бүтээгдэхүүн						
Жонш	206.7	233.4	239.4	245	219.1	344.2
Жонш баяжмал	102.7	93.7	108.3	109.9	115.7	115.3
Зэсийн баяжмал	130	126.3	129.7	130.2	126.8	129.8
Молибдений баяжмал	1.14	1.15	1.41	1.98	1.78	2.41
Цагаан тугалгийн баяжмал/50%/	0.022	0.047		0.03	0.09	0.015
Вольфрамын баяжмал/68%/	0.077	0.078	0.182	0.244	0.142	0.039
Нүүрс	6665	7517.1	8074.1	9237.6	9691.6	13164
Алт	0.019	0.022	0.021	0.018	0.015	0.001
Катод зэс	2.38	2.48	2.62	3.01	2.59	2.47
Төмрийн хүдэр	33.5	167.7	180	265.1	1387.4	1379.0
Цайрын баяжмал /нойтон/		22.8	109.9	154.7	143.6	156.5
Каст зэс		0.20	0.22			
Молибдений хүчил			0.16	2.66	2.11	0.157

2008 оны хувьд Монгол улсын нийт экспортын орлогын 75% эрдэс баялагийн бүтээгдэхүүний экспортоос бүрджээ. Үүний 33% нь зэс, 24% нь алт, 7% нь нүүрс, 4% нь газрын тос, 6% нь цайр эзэлжээ. Нийт экспортын орлогын 66%-ийг БНХАУ-с, 17%-ийг Европоос, 11%-ийг Канад болон АНУ-с, 3%-ийг ОХУ-с мөн үлдсэн хувийг бусад улс орноос авчээ. (АМГ, 2009; Дэлхийн Банк).

Мөн АМГ нь тухайн салбарын санхүүгийн хувьд оруулж буй хувь нэмрийг бас нэгтгэн гаргадаг. Үүнийг дор хүснэгтээр харуулав.


Уул уурхайн салбарын улсын эдийн засагт үзүүлж буй үүрэг роль



3.2. Нүүрс


■ - In GDP ■ - In manufacturing industry ■ - In export

Нүүрсний ордны хувьд томоохон хэмжээтэй нь нутаг дэвсгэрийнхээ зүүн хэсгээр түгээмэл оршдог ч ерөнхийдөө тархаж байрладаг.



Монгол улс нь дэлхийн хэмжээнд нүүрсний ордын хувь хэмжээгээрээ тэргүүлэх байр суурь эзэлдэг ба геологийн нөөцийн хувьд бараг 162.3 тэрбум тонн хүрэх бөгөөд нүүрсний чанарын хувьд нүүрсний шатнаас антрацит ангилал хүртэл байдаг.

Үйлдвэрлэлийн хувьд сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа ба дотоодын хэрэгцээ нь тогтмолжиж, экспортлох байдал нь голчлон БНХАУ руу төвлөрч байгаа.



Эх сурвалж: АМГ-ын веб хуудас

3.3. Газрын тос

Монголын нийт орд газрын 25 хайгуулын хэсэгт олон улсын сонгон шалгаруулалт зарлагдсан ба Монголын АМГ нь дахин 4 газар дээр зарлахаар ажиллаж байна. Хайгуулын хэсгүүд нь гол төлөв нутгийнхаа өмнөд хагас, түүнчлэн төв, зүүн болон баруун хэсгээр оршдог. Зүүн говийн хэсэг нь ерөнхийдөө газрын тосны 4 дэд-бэлчир хэсэгт хуваагддаг.

Зүүн Баянгийн бэлчир хэсэг нь 1941 онд нээгдсэн ба эрчимтэй хайгуул болон олборлолтын ажил хийгдсэн. Тамсагийн бэлчир хэсэг нь Монголын зүүн хэсэгт байдаг бөгөөд 1990-2001 оны хавьд нээгдсэн ба БНХАУ-ын Үндэсний Тосны Корпораци нөөцийн судалгаа хийж 1.5 тонн хэмээн тогтоожээ. Сүүлийн жилүүдэд, нутгийн баруун хэсгийн Цагаан Элс болон бусад орд газруудад хайгуулын болон олборлолтын ажлууд хийгдсээр ирсэн. 1994-2008 оны хайгуулын ажлын хүрээнд нийт 17,600 км талбайн ажил нь 1 км газрыг хамарсан 2 талт, 6,000 км газрыг хамарсан 3 талт

ажлууд болон 448 худгийн өрөмдлөг, 952 сая ам. долларын шууд гадаадын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

2008 онд нийт газрын тосны хайгуул болон олборлолтын ажлыг Канадын 1 компани (Шаман Ресорси ХХК); Хятадын 3 компани (Петро Чайна Дачин Тамсаг-Монгол ХХК, Доншин Петролиум ХХК болон Чайна Голден Сий ХХК), ба Монголын 1 компани (Петро Матад ХХК) нар хийж гүйцэтгэсэн байна. Тосон-Уул болон ПЭССИ-97 нь 50 ба 31 үйлдвэрлэлийн худаг тус тус гаргах ажил хийгдсэн байна. Тосон-Уул нь өдөрт 3,800 тэрбум, ПЭССИ-97 өдөрт 1,800 тэрбум олборлолт хийж өссөн дүнгээрээ нийт 3.4 сая (3.1 сая нь экспортлогдсон, учир нь Монгол улс нь өөрийн газрын тос боловсруулах үйлдвэр байхгүй). Нийт улсын хэмжээнд, 2010 гэхэд "Петро Чайна Дачин Тамсаг-Монгол" ХХК нь жил бүр ойролцоогоор 3 сая орчим бареллийг үйлдвэрлэх боломжтой байгаа ба энэ тооцоо 11.3 саяд хүрэх магадлалтай байна.

4. ХАНДЛАГА

4.1 Үндсэн суурь ба материаллаг байдал

2008 онд СЯ-ны зүгээс 2008 оны ОУИТБС-ын Нэгтгэлд ашиглагдахаар Ажлын Хэсгээс батлан гаргасан маягтын дагуу бөглөн ирүүлсэн олборлох үйлдвэрлэл эрхэлдэг 184 компанийн ЗГ-ын хүлээн авсан дүнг харуулсан тайланг гаргасан. Энэхүү тайланд хамрагдсан бүхий л байгууллагууд, аймгууд болон сумд, Засгийн газрын харъяа яам, агентлагууд болон бусад байгууллагуудыг “Засгийн газрын байгууллагууд” гэсэн тодотголтойгоор нэрлэсэн ба эдгээрийг Хавсралт Ж-д харуулсан.

Ажлын Хэсгийн зааварласны дагуу 2008 онд 100 сая төгрөг болон түүнээс дээш төлбөр хийсэн компаниудыг маягтаа хүргүүлэхийг СЯ-аас хүсэмжилсэн. Үүний дагуу 46 компани бүртгэгдсэн ба эдгээрийг “Хамрагдсан компаниуд” гэсэн тодотголтойгоор нэрлэсэн ба Хавсралт Ж-д бас харуулсан.

Сангийн Яамны зүгээс хамрагдсан 46 компанийн төлсөн нийт дүнг ЗГ-ын хүлээн авсан дүнтэй зэрэгцүүлэн гаргасан хүснэгтүүд нь бидний нэгтгэлийн ажилд суурь болсон.

Нийт төлбөр болон орлогын хооронд үүсэх зөрүүг хянан үзэх материаллаг байдал дээр Ажлын Хэсгийн зүгээс аливаа нэгэн заавар удирдамж гаргаж өгөөгүй. 2010 оны 5-р сарын 14-ний өдөр бид шийдэгдээгүй зөрүүнүүдийн дүнг урьдчилсан тайлангаараа АХ-т танилцуулсан. АХ-т урьдчилсан байдлаар танилцуулсны дараа АХ-ийн хүссэний дагуу 27 компанитай холбогдуулан нэмэлт мэдээлэл авах шаардлагатай болсоны үндсэн дээр ҮТЕГ-аас 2010 оны 5-р сарын 25-ны дотор мэдээллээ гаргаж өгөх, түүнчлэн шийдэгдээгүй зөрүүнүүдийн талаар тайлбар өгөхийг хүсэмжилсэн албан бичгийг холбогдох компаниуд руу илгээсэн.


Энэхүү тайлан нь 2010 оны 5-р сарын 27-ныг хүртэл хүлээн авсан хариуны дагуу ирсэн бүхий л мэдээллүүдийг багтаасан болно.

4.2 Хандлага ба арга

Бидний энэхүү ажилд хэрэглэсэн арга хандлагын талаар товч дурьдвал:

- Монголын ОУИБСА-тай нягт харилцан ярилцаж, Монголын ОУИБС-ын заавар, журмуудтай танилцан, бүрэн гүйцэд ойлголт авсан, холбогдох бичиг баримтуудыг үзэх, ялангуяа, тайлагнах маягтуудад зориулан боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, аргачлал хандлагууд болон боловсруулсан алдааны хязгаар зэрэгтэй танилцсан.
- Хамрагдсан компаниудын маягтуудын мэдээллийг нэгтгэн хүснэгтлэх, эдгээр маягтуудад буруу зөрүү (шаардлагын дагуу мянгачлагдаагүй дүн) бөглөгдсөн зүйлсийг хасан (татварын торгууль, акт гэх мэт) зохих залруулгыг хийсэн. Тайлагнагдсан дүнг аль болох зөрүүгүй шийдвэрлэх зорилгын үүднээс нэгтгэлийн ажлыг гүйцэтгэсэн.
- Зөрүүнүүдийг шийдвэрлэхийн тулд компаниуд болон Засгийн газрын байгууллагуудтай хамтран ажилласан.
- Нэгтгэлийн явцад хийгдсэн бүхий л залруулгуудыг тайлбарласан.

4.3 Ажлын чиглэл, хоорондын уялдаа



4.4 Аргачлал

Уул уурхайн компаниудын өгөгдлүүд буюу тоон үзүүлэлтүүд нь Монголын ОУИТБСАА-аас гаргасан Маягт №1 дээр тайлагнагдсан ба тухайн маягт нь компанийхаа аудитораар шалгагдалгүй бэлтгэгдсэн болохыг бид ажигласан. Тиймээс, бид Удирдлагын хариуцлагын захидлыг бэлтгэн компани тус бүрийн Захирлуудын зөвлөлд илгээж, тайлагнасан мэдээлэл нь компанийн аудиторoor хянагдсан эсэхийг баталгаажуулахыг зорьсон. Энэ талаар Хавсралт Д-д харуулсан болно.

Маягт №1 нь дараахи үндсэн 2 бүлэгтэй:

Хүрээ 1: Хүрээ 1 нь үндсэн 2 хэсгээс бүрдэх ба эхний хэсэгт олборлох үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын дүнг биет нэгж болон мөнгөн дүнгээр илэрхийлсэн байна. Хоёр дахь хэсэгт олборлох үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын Засгийн газарт төлсөн татварууд, төлбөрүүд, төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг, хүлээн авагч засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд, засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, тусламжууд болон байгаль хамгаалахтай холбогдон гарсан зардлуудыг илэрхийлдэг.

Хүрээ 2: Орлогууд ба орлогын урсгалууд (сайн дурын үндсэн дээр)

Уул уурхайн компани тус бүрийн Маягт №1 дээрх үзүүлэлт бүрээр тайлагнасан төрийн болон орон нутгийн төсөвт төлсөн татварууд болон төлбөрүүдийг ЭКСЕЛ программын хүснэгтүүдийг ашиглан Засгийн газрын байгууллагуудын бэлтгэсэн тайлантай (Монголын ОУИБСА-аас гаргасан Маягт № 2 ба 3) компани тус бүрээр тулгасан болно.

Ийнхүү тулгах явцад үүссэн бүхий л зөрүүнүүдийг тогтоосон шалгуурын дагуу ач холбогдолтой буюу ач холбогдолгүй гэж ангилан хүснэгтэлсэн.

Үүссэн ач холбогдолтой зөрүүнүүдийн хувьд МОУИТБСА-аас гаргасан Маягт №3 дээрх нэгтгэсэн дүнгүүдийг ЗГ-ын байгууллагууд болон УТЕГ-аас Монголын ОУИБСА-аас гаргасан Маягт №2-ын дагуу ирүүлсэн мэдээллүүдээс шалгасан.


Ач холбогдолтой зөрүү бүрийн хувьд дараахи зүйлсийг тодорхойлно.


- Холбогдох ЗГ-ын байгууллагууд ба татварын албадаас (Маягт №2 дээрх дүнг харуулах үүднээс хүлээн авсан дүн буюу орлогын хийгдсэн он сар өдөр, дүнгүүдийн дэлгэрэнгүй) дэлгэрэнгүйг авсан. Энэхүү дэлгэрэнгүйг уул уурхайн компаниудын төлсөн төлбөрүүдийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй тулган шалгахад хэрэглэсэн ба тэгснээр зөрүүнүүдийн боломжит тайлбаруудыг олж авсан.
- Уул уурхайн компаниудын бэлтгэсэн Маягт №1 нь тус компанийхаа аудиторoor хянагдсан эсэхийг мэдсэний үндсэн дээр тухайн компанийн хувьд үүссэн зөрүүнүүдийн тоо хэмжээ, төрөл (үзүүлэлт) болон бусад холбогдох хүчин зүйлсийн талаар бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмж шүүмжлэлийг ашиглан дараахи байдлаар шийдвэр гаргасан. Үүнд:
 - Монголын ОУИТБСА-аас гаргасан Маягт №1 дээрх өгөгдлүүдийн үнэлгээний байдлыг хянаж үзэх. Бид энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Зөвшилцсон горимоор гүйцэтгэх нэгтгэлийн олон улсын стандартыг ашигласан. Үүний тулд гүйцэтгэсэн горимууд нь үзүүлэлт бүрийн шинж чанараас хамаарч болно, түүнчлэн өөр бусад төрлийн эх сурвалж болох баримт бичгүүдийг ашиглах, дүн шинжилгээний хяналт, тоонуудыг батлан нотлохын тулд хийгдэх хараат бус тулган баталгаажуулалт зэргээс бүрдсэн. Хандлагын хувьд зөвхөн тодорхойлогдсон ач холбогдолтой зөрүүнүүдийн хувьд ч бус зарим тохиолдолд компанийн тайлагнасан бүхий л болон хэсэг өгөгдлүүдийг ч хамран хийгдэх шаардлага гарч байсан.
 - Монголын ОУИБСА-аас гаргасан Маягт №1-ээр ирүүлсэн тоонуудын тооцооллыг харж шалгахын тулд холбогдох компаниудын зүгээс тэдний тайланд тусгагдсан дүнгийн

дэлгэрэнгүй задаргааг (төлбөр хийгдсэн он сар өдөр болон дүнгүүд) авах хүсэлтийг гаргасан.

- Ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр хангалттай тайлбар олж аваагүй тохиолдолд бид хянан шалгах үйл явцыг илүү түлхүү явуулсан.
- Хэрвээ дээрх үйл явцын хүрээнд зөрүүнүүд нь шийдвэрлэгдэх боломжгүй гэж тооцогдвол холбогдох ЗГ-ын байгууллагууд болон тухайн компанийн хүмүүстэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж шийдвэрт хүрэх арга хэмжээг авсан.
- Тулган шалгах явцад тодорхойлогдсон зөрүүнүүдийг ангилж, зөрүүний шалтгааныг (эсвэл шаардлагатай бол шийдэгдээгүй байдлаар нь үлдээх) тайлбарласан. Энэ нь Маягтуудыг бэлтгэх явцад голлон үүсдэг асуудлууд болон ОУИТБСА-ны ажлын явцыг тодорхойлоход чиглэл, зөвлөмжүүдийг өгсөн.


4.5 Талуудын оролцооны схем






4.6 Хамрагдсан компаниуд


Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланд орж байгаа нийт 46 компанийг эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл дараах байдалтай байна.



2008 оны татварын жилд Монгол улсын ЗГ-т төвлөрүүлсэн татварын хэмжээг аудитад хамрагдсан 46 компанийн хувьд авч үзвэл дараах бүтэцтэй байна.



Компаниудын 2008 онд улсад төлсөн татварын дүнг хувийн жингээр нь нь харуулбал:



Дээрх диаграммаас харахад “Эрдэнэт Үйлдвэр” ХХК нь татварыг хамгийн өндөр хэмжээгээр төлдөг компани бөгөөд мөн 46 компанийн ихэнх бага хэмжээгээр төлөлт хийдэг нь харагдаж байна.

5. САНХҮҮГИЙН УРСГАЛЫН НЭГТГЭЛ

5.1 Анхлан тайлагнасан санхүүгийн нийт урсгал

Хамрагдсан компаниудаас ирүүлсэн маягтуудыг анхлан шалгах явцад ихэнх компаниуд нь НӨАТ, ХХОАТ болон бусад оруулах ёсгүй байсан төлбөрүүдийг оруулан тайлагнасан болох нь ажиглагдсан. Мөн “Шижир Алт” ХХК нь маягтыг бгөлөхдөө шаардлагын дагуу мянгачилалгүй шууд төгрөгөөр бөглөн ирүүлсэн.

Шаардлагын дагуу тайлагнан оруулах ёсгүй байсан татварын төрлүүдийг хасч, мөн “Шижир Алт” ХХК-ийн дүнг мянгачлан оруулсны дараа анхны нийт цэвэр зөрүү **(47,148,870 мянган)** төгрөг болсон.

Бүлэг	Тайлагнасан байдал		Анхны цэвэр зөрүүнүүд мян.төг
	Засгийн газрын нэгж байгууллагууд	Компаниуд	
	мян.төг	мян.төг	
1 Татварууд	513,176,775	529,354,346	(16,177,571)
2 Төлбөрүүд	117,144,724	118,715,936	(1,571,211)
3 Хураамжууд, үйлчилгээний шимтгэлүүд	2,434,776	2,918,513	(483,737)
4 Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	27,349,905	21,133,422	6,216,483
5 Хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд	-	26,669,948	(26,669,948)
6 Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандивууд	1,048,225	10,364,538	(9,316,313)
7 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	4,580,546	3,727,118	853,428
Нийт	665,734,951	712,883,821	(47,148,870)

Доорх хүснэгт нь компаниудын ирүүлсэн маягтын дүнгүүдийг ЗГ-аас ирүүлсэн маягтын дүнгүүдтэй харьцуулан гаргасан цэвэр дүнгүүдийг харуулж байна. Цэвэр зөрүүг задлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

	мян.төг
Компаниудын төлсөн дүн ЗГ-ийн хүлээн авсан дүнгээс их	(54,218,782)
ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их	7,069,911

5.1.1 2010 оны 5 сарын 14 өдөр Ажлын Хэсэгт тайлагнасан нийт санхүүгийн урсгал

Анхлан тайлагнагдсан тоон дүнгүүдийг нэгтгэх явцад компаниуд болон Засгийн газрын байгууллагуудтай олон удаа уулзалт хийж ярилцсаны дараагаар бид 2010 оны 5 сарын 14- ний өдөр ажлынхаа явцыг танилцуулах үүднээс МОУИТБС-ын Ажлын Хэсэгт урьдчилсан байдлаар танилцуулсан.

Тухайн үед буюу урьдчилсан тайлангийн байдлаар шийдэгдээгүй зөрүүнүүд дараахи байдалтай байсан.

Бүлэг	Анхны цэвэр зөрүүнүүд	Тайлагнасан байдал		Шийдэгдээгүй цэвэр зөрүүнүүд
		Засгийн газрын нэгж байгууллагууд	Компаниуд	
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
5.1 Татварууд	(16,177,571)	571,368	(13,649,744)	(1,956,459)
5.2 Төлбөрүүд	(1,571,212)	(14,244,097)	(13,263,934)	(2,551,375)
5.3 Хураамжууд, үйлчилгээний шимтгэлүүд	(483,737)	52,050	(73,882)	(357,805)
5.4 Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	6,216,483	-	6,216,483	-
5.5 Хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд	(26,669,948)	26,636,793	-	(33,155)
5.6 Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандивууд	(9,316,313)	1,735,053	(3,948,674)	(3,632,586)
5.7 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	853,428	(3,636)	841,769	8,023
Нийт	(47,148,870)	14,747,531	(23,877,983)	(8,523,356)

Доорх хүснэгт нь компаниудын ирүүлсэн маягтны дүнгүүдийг Засгийн газраас ирүүлсэн маягтны дүнгүүдтэй харьцуулан гаргасан цэвэр дүнгүүдийг харуулж байна. Цэвэр зөрүүг задлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

	Мян.төг
Компаниудын төлсөн дүн ЗГ-ийн хүлээн авсан дүнгээс их	(54,218,781)
ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их	7,069,911
	8,023

5.2 Залруулга ба Нэгтгэлийн дараахи нийт санхүүгийн урсгал

Ажлын Хэсэгт урьдчилсан байдлаар танилцуулсны дараа 27 компанитай холбогдуулан нэмэлт мэдээлэл авах шаардлагатай болсны үндсэн дээр УТЕГ-аас 2010 оны 5 сарын 25-ны дотор мэдээлэлээ гаргаж өгөх, түүнчлэн шийдэгдээгүй зөрүүнүүдийн талаар тайлбар өгөхийг хүсэмжилсэн албан бичгийг холбогдох компаниуд руу илгээсэн.

Энэхүү оролцооны тусламжтайгаар бид энэхүү тайландаа 2010 оны 5 сарын 27-ийг хүртэл ирсэн мэдээллүүдийг хамруулан ажлаа хийж гүйцэтгэсэн.

Ингэснээр бидний нэгтгэлийн ажлын үр дүнд шийдэгдээгүй зөрүүнүүд доорхи байдалтай болж өөрчлөгдсөн. Үүнд:

Бүлэг	Анхны цэвэр зөрүүнүүд	Тайлагнасан байдал		Шийдэгдээгүй цэвэр зөрүүнүүд
		Компаниуд	Засгийн газрын нэгж байгууллагууд	
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
5.1 Татварууд	(16,177,571)	821,835	(15,428,524)	72,788
5.2 Төлбөрүүд	(1,571,212)	(11,678,010)	(13,172,267)	(76,955)
5.3 Хураамжууд, үйлчилгээний шимтгэлүүд	(483,737)	52,050	(74,897)	(356,790)
5.4 Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	6,216,483	-	6,216,483	-
5.5 Хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд	(26,669,948)	26,669,948	-	-
5.6 Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандивууд	(9,316,313)	4,893,179	(4,353,078)	(70,056)
5.7 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	853,428	(1,540,781)	(17,960)	(669,394)
Нийт	(47,148,870)	19,218,221	(26,830,242)	(1,100,407)

Цэвэр зөрүүг задлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

	мян.төг
Компаниудын төлсөн дүн ЗГ-ийн хүлээн авсан дүнгээс их	(54,218,781)
ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их	7,069,911
	72,788

Шийдэгдээгүй зөрүүнүүдийн дийлэнх нь засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, тусламжийн дүнтэй холбогдон үүссэн. Компаниудын зүгээс энэ төрөлд тайлагнасан нийт дүн нь 2007 онтой харьцуулахад нилээд хэмжээгээр өссөн нь доорхи хүснэгтээс харагдаж байна. Энэ нь 2007 онд 38 компани нэгтгэлд хамрагдсан бол 2008 онд 46 компанид сонголт хийж нэмэгдсэнтэй зарим талаараа холбоотой.

	Засгийн газрын байгууллагуудын тайлагнаснаар	Компаниудын тайлагнаснаар	Анхны зөрүүнүүд
2007 он	1,776,238	6,543,559	(4,767,321)
2008 он	1,048,225	10,364,538	(9,316,313)
Зөрүү	(728,013)	3,820,979	4,548,992

Нэгтгэлийн үр дүнд анхлан ирүүлсэн маягтуудын дүнд хийгдсэн залруулгуудын талаар илүү дэлгэрэнгүйг Хавсралтуудаар харуулсан ба түүнчлэн санхүүгийн урсгалаар нь (Хавсралт А) болон компаниар нь (Хавсралт Б) тус тус дүгнэн шинжилсэн болно.

Нэгтгэлийн дараахи байдлаар шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүдийг Бүлэг 6-д дахин дэлгэрэнгүй тайлагнасан болно.

6 ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНҮҮД

6.1 Нийт шийдэгдээгүй зөрүүнүүд

Дүнгүүдийг нэгтгэсний дараа тодорхой тооны зөрүүнүүд нь шийдэгдээгүй үлдсэн ба үүнийг санхүүгийн урсгалаар нь илүү дэлгэрэнгүй энэхүү бүлэгт тайлбарласан болно.

Засгийн газрын байгууллагууд болон компаниудын анхны зөрүүнүүдийн хураангуй, нэгтгэлийн үр дүнд хийсэн залруулгууд болон шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүдийг дараахи байдлаар харуулав. Үүнд:

Бүлэг	Анхны зөрүүнүүд, цэвэр мян.төг	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
5.1 Татварууд	(16,177,571)	821,835	(15,428,524)	72,788
5.2 Төлбөрүүд	(1,571,212)	(11,678,010)	(13,172,267)	(76,955)
5.3 Хураамж, үйлчилгээний шимтгэлүүд	(483,737)	52,050	(74,897)	(356,790)
5.4 Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	6,216,483	-	6,216,483	-
5.5 Хүлээн авагч засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд	(26,669,948)	26,669,948	-	-
5.6 Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандивууд	(9,316,313)	4,893,179	(4,353,078)	(70,056)
5.7 Байгаль хамгаалах зардал	853,428	(1,540,781)	(17,960)	(669,394)
Нийт	(47,148,870)	19,218,221	(26,830,242)	(1,100,407)

Доорх хүснэгт нь оролцогч талуудын дүнгүүдийг харьцуулснаар төлсөн болон хүлээн авсан дүнгийн цэвэр зөрүүг задлан харуулав.

	мян.төг
Компаниудын төлсөн дүн ЗГ-ийн хүлээн авсан дүнгээс их	(54,218,781)
ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их	7,069,911

Шийдэгдээгүй 1,100,407 мянган төгрөгийн зөрүүг компани тус бүрээр задлан харуулбал дараах бүтэцтэй байна.

Компаниуд	Шийдэгдээгүй зөрүүнүүд мян.төг
<u>Компаниудын төлсөн дүн ЗГ-ийн хүлээн авсан дүнгээс их</u>	
"Бороо гоулд" ХХК	(1,140,161)
"Монголросцветмет" ХХК	(893,452)
"Эрдэнэт үйлдвэр" ХХК	(130,440)
"Айвенхоу майнз монголия инк" ХК	(126,811)
"Чинхуа МАК нарийн сухайт" ХХК	(120,361)
"Болд төмөр ерөө гол" ХХК	(109,750)
Бусад (43,000 мянган төгрөгөөс доош төлбөрүүдийн дүн)	(163,837)
Бүгд	(2.684.812)
<u>ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их</u>	
"Цайрт минерал" ХХК	1,435,782
"Монгол газар" ХХК	101,747
Бусад (44,200 мянган төгрөгөөс доош төлбөрүүдийн дүн)	46,876
Бүгд	1,584,404

6.2 Татварууд

Татваруудын хувьд шийдэгдээгүй зөрүү нь голчлон гаалийн албан татвар, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвараас үүссэн. Материаллаг зөрүү үүссэн компаниудыг жагсаалтаар харуулав. Үүнд:

Компаниуд	Шийдэгдээгүй зөрүүнүүд Мян.төг
<i>Компанийн төлсөн дүн ЗГ-ын тайлагнасан дүнгээс их</i>	
"Багануур" ХХК	(8,436)
"Шижир талст" ХХК	(679)
Бусад (350,0 мянган төгрөгөөс доош төлбөрүүдийн дүн)	(644)
Дүн	(9,759)
<i>Компанийн төлсөн дүн ЗГ-ын тайлагнасан дүнгээс бага</i>	
"Тавантолгой" ХХК	50,105
"Монгол газар" ХХК	19,029
"Бороо гоулд" ХХК	7,458
"Тэн хун" ХХК	4,866
Бусад (600,0 мянган төгрөгөөс доош төлбөрүүдийн дүн)	1,088
Дүн	82,546

Шийдэгдээгүй зөрүү үүссэн гол шалтгаан нь:

- "Багануур" ХХК нь 2008 онд санаачилгын албанд гаргаж өгсөн тайландаа гаалийн албан татварыг тайлагнаагүй, нэгтгэлийн явцад нөхөн гаргаж өгсөн ба шийдвэрлэгдээгүй зөрүү нь гаалийн байгууллага ногдуулалтаараа, компани нь төлөлтөөрөө тайлан гаргаж өгч байгаа тул компанийн ирүүлсэн дүнд гаалийн үйлчилгээний хураамж болон бусад зуучлагч компаниудад төлсөн дүнг оруулж тайлагнасан. Компани зөвхөн гаалийн албан татварын дүнг бидэнд салгаж өгч чадахгүй байгаатай холбоотой зөрүү үүсээд байна.
- "Таван толгой" ХХК-иас ЗГ нь 50,105 мянган төгрөгийн гаалийн албан татвар хүлээн авсан гэж тайлагнасан ба компанийн зүгээс тайлагнаагүй. Дэлгэрэнгүй мэдээллийг тус компани гаргаж ирүүлээгүй учраас ЗГ-ын хүлээн авсан дүнг нотолж, зөрүүг шийдвэрлэж чадсангүй.
- "Монгол газар" ХХК нь 2008 оны санаачилгын албаны тайланг гаргаж өгөөгүй ба нэгтгэлийн явцад бид компанийн удирдлагуудтай очиж биечлэн уулзаж, дэлгэрэнгүй мэдээллийг гаргуулж авсан. Дэлгэрэнгүй мэдээлээр гаалийн албан татварт 33,366 мянган төгрөгийг төлсөн гэж байгаа боловч энэ нь Гаалийн ерөнхий газраас гаргаж өгсөн мэдээллээс 20,474 мянган төгрөгөөр зөрүүтэй байсан энэ дүн шийдэгдэгдэхгүй үлдээд байна.
- ЗГ "Тэн хун" ХХК-иас төлсөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хүлээн авсан талаар дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж ирүүлээд байхад компаниас төлсөн дүнгээ дэлгэрэнгүй мэдээллээр баталгаажуулж өгөөгүйгээс шалтгаалаад 3,248 мянган төгрөгийн зөрүү үүсээд байна.
- Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварын шийдвэрлэгдээгүй зөрүү нь "Шижир талст" ХХК дэлгэрэнгүй мэдээлэлдээ уг татварыг Дархан уул аймгийн татварын хэлтэст 678,8 мянган төгрөг төлсөн гэж тусгасан хэдий ч ЗГ-ын байгууллага буюу Дархан уул аймгийн татвараас ямар нэгэн дүн ирүүлээгүйгээс зөрүү шийдэгдээгүй.
- Мөн "Бороо гоулд" ХХК-ийн хувьд ЗГ болон компани нь анхлан тайлагнасан дүнгээ дахин өөрчлөн ирүүлсэн ба эдгээр залруулгуудыг хийсний дараа шийдэгдээгүй зөрүү 7,458 мянган төгрөг болсон. Уг зөрүүг шийдвэрлэхийн тулд тус компанийн татвар хариуцсан нягтлан бодогч руу захидал илгээсэн боловч хариу ирүүлээгүй.
- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувьд "Тэн хун" ХХК-иас уг татварын талаар ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэл болон ЗГ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дүнгээр залруулга хийсэн хэдий ч 3,480 мянган төгрөгийн татварын зөрүү шийдвэрлэгдээгүй.

6.3 Төлбөрүүд

Төлбөрүүдийн хувьд шийдэгдээгүй зөрүү нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр, газрын төлбөр, ус, рашаан ашигласны төлбөр, гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэргээс үүссэн. Материаллаг зөрүүтэй компаниудыг дараахи хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

Компаниуд	Шийдэгдээгүй зөрүүнүүд Мян.төг
<i>Компанийн төлсөн дүн ЗГ-ын тайлагнасан дүнгээс их</i>	
"Тэн хун" ХХК	(34,440)
"Монгол газар" ХХК	(17,152)
"Бороо гоулд" ХХК	(16,972)
"Цайрт минерал" ХХК	(10,492)
Бусад (3,250 мянган төгрөгөөс доош төлбөрүүдийн дүн)	(5,796)
Дүн	(84,852)
<i>Компанийн төлсөн дүн ЗГ-ын тайлагнасан дүнгээс бага</i>	
"Багануур" ХХК	4,866
"Шивээ овоо" ХХК	2,556
Бусад(400,0 мянган төгрөгөөс доош төлбөрүүдийн дүн)	476
Дүн	7,898

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн шийдэгдээгүй зөрүү үүссэн гол шалтгаанууд нь:

- "Монгол газар" ХХК нь анхны тайлан болон дэлгэрэнгүй мэдээлэлдээ 91,385 мянган төгрөгийн төлбөр төлсөн, ЗГ 71,752 мянган төгрөгийн төлбөр хүлээн авсан гэж тайлагнасан. Үлдээд байгаа 19,633 мянган төгрөгийн төлбөр шийдвэрлэгдээгүй.

Газрын төлбөр, ус, рашаан ашигласны төлбөрийн зөрүү үүссэн гол шалтгаан нь:

- ЗГ-ын тайлангийн дүнд компанийн уурхайн байршлын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагт төлсөн төлбөр тусгагдаагүй байсан ба эдгээр дүнг тохируулах зорилгоор орон нутгийн татварын албанд хандаж мэдээллийг авч залруулсан хэдий ч "Цайрт минерал", "Эрэл", "Тэн хун" зэрэг компаниудын төлсөн дүн баталгаажаагүйн улмаас зөрүү шийдвэрлэгдээгүй.

Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрийн зөрүү үүссэн шалтгаан нь:

- "Тэн хун" ХХК дэлгэрэнгүй мэдээллээрээ 121,000 мянган төгрөгийн төлбөр төлсөн, ЗГ-аас 92,520 мянган төгрөгийн төлбөр хүлээн авсан гэж дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж ирүүлсэн. Хоёр талын мэдээлэлд үндэслэн залруулгыг хийсэн боловч 28,480 мянган төгрөгийн зөрүү шийдвэрлэгдээгүй.

6.4 Хураамж, үйлчилгээний шимтгэлүүд

Хураамжийн хувьд шийдэгдээгүй зөрүү нь зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс, гаалийн бүрдүүлэлтийн хураамж зэргээс үүссэн. Материаллаг зөрүүтэй компаниудыг дараахи хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

Компаниуд	Шийдэгдээгүй зөрүүнүүд Мян.төг
<i>Компанийн төлсөн дүн ЗГ-ын тайлагнасан дүнгээс их</i>	
"Чинхуа МАК Нарийн сүхайт" ХХК	(120,361)
"Айвенхоу майнз монголия инк" ХХК	(112,482)
"Монголын алт МАК" ХХК	(43,213)
"Бороо гоулд" ХХК	(21,613)

Компаниуд	Шийдэгдээгүй зөрүүнүүд Мян.төг
"Жамп" ХХК	(16,590)
"Зүрийн булан" ХХК	(10,900)
Бусад (6,000 мянган төгрөгөөс доош төлбөрүүдийн дүн)	(33,326)
Дүн	(358,486)
<i>Компанийн төлсөн дүн ЗГ-ын тайлагнасан дүнгээс бага</i>	
Болд төмөр Ерөө гол	1,267
Монгол газар	429
Дүн	1,696

Хураамж

Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлсний зөрүү үүссэн гол шалтгаан нь:

- Уг хураамжийг ЗГ-ын тайланд нэгтгэх мэдээллийн урсгал нь тодорхой бус, ОУИТБС-ын "Маягт-1"-ыг нөхөх арга аргачлалд ямар хураамж, үйлчилгээний хөлсийг тусгахыг нарийвчлан заагаагүй зэргээс шалтгаалсан.
- Компаниуд хураамж болон үйлчилгээний хөлсийг зардлын нэр төрлөөр тайлагнасан нь санхүүгийн тайланд тодорхой харагдахгүй байгаагаас ЗГ-ын нэгтгэл тайланд тусгагдахгүй байна.
- Компанийн тайлангийн дүнг тохируулах үүднээс орон нутгийн байгууллагууд руу тулган баталгаажуулах захидал илгээсэн хэдий ч орон нутгийн төрийн албан хаагчид хариу ирүүлэх ажилд санаачлага гаргахгүй, хариу ирүүлсэн ч бүрэн гүйцэд мэдээлж чадахгүй байна.

Гаалийн үйлчилгээний хураамжийн зөрүү үүссэн гол шалтгаан нь:

- Компаниуд гаалийн татварын дүнд гаальд төлсөн НӨАТ, гаалийн үйлчилгээний хураамжийг багц дүнгээр нь бүртгэж тайлагнаж байгаагаас зөрүүг шийдвэрлэхэд хүндрэлтэй байна.

6.5 Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг

Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашгийн анхны зөрүү дүнг тодруулахаар компани болон ЗГ-ын харьяа байгууллагад албан бичиг хүргүүлсний дагуу дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэж залруулга хийгдсэнээр шийдэгдээгүй зөрүү үлдээгүй болно.

6.6 Хүлээн авагч засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд

Анхны нэгтгэл тайлангаар үүссэн зөрүүг тодруулахаар компани болон ЗГ-т албан бичиг илгээсэн. ГТГ-аас болон компаниудаас ирсэн дэлгэрэнгүй мэдээллүүдэд үндэслэн залруулгуудыг хийснээр зөрүүнүүдийг бүрэн шийдвэрлэсэн.

6.7 ЗГ-ын байгууллагуудад өгсөн хандивууд

Компаниуд	Шийдэгдээгүй зөрүүнүүд Мян.төг
<i>Компанийн төлсөн дүн ЗГ-ын тайлагнасан дүнгээс их</i>	
"Монголросцветмет" ХХК	(38,390)
"Гоби коул энд энерги" ХХК	(12,350)
"Шарын гол" ХК	(11,096)
"Цайрт минерал" ХХК	(4,420)
"Дацан трейд" ХХК	(2,000)
"Болд төмөр ерөө гол" ХХК	(1,300)

Компаниуд	Шийдэгдээгүй зөрүүнүүд Мян.төг
"Таван толгой" ХХК	(500)
Дүн	(70,056)
<i>Компанийн төлсөн дүн ЗГ-ын тайлагнасан дүнгээс бага</i>	
Дүн	-

Хандив тусламжийн анхны нийт зөрүү 9,316,313 мянган төгрөг буюу нийт зөрүүний 20%-ийг эзэлж байсан. Энэ нь хандив тусламжийн орлогыг нэгтгэж тайлагнадаг, зарцуулалт үр ашигт нь хяналт тавьдаг ЗГ харъяа байгууллага байхгүй байгаатай шууд холбоотой юм.

Бид 2008 оны нэгтгэл тайлангийн ажил эхлээд зөрүү үүссэн компаниудын үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгуудын Засаг дарга нарт албан тоот хүргүүлсэн. Гэтэл компаниудаас дэлгэрэнгүй мэдээллүүд ирж, үүнд аймгийн ЗДТГ-аас гадна өөр бусад албан байгууллагуудад өгсөн болох нь тогтоогдсон. Үүний дагуу хандив өгсөн гэсэн бүх албан байгууллагуудад дахин албан тоот бэлтгэж, хүргүүлсэн. Зарим сум орон нутгийн холбоо, мэдээлэл хэрэгслийн дутмаг байдал, төрийн ажилтангуудын хүнд суртал, хөшүүн хойрго байдал нилээд хүндрэл учруулсан. Гэхдээ олон удаагийн шаардлагаар ихэнх сум орон нутгаас хариу захидал авч зөрүүнүүдийг шийдвэрлэсэн. Мөн манай багийн гишүүн Сэлэнгэ болон Дархан Уул аймгуудад биеэр очиж ажилласан нь зөрүү шийдвэрлэгдэхэд нөлөө үзүүлсэн.

Дээрхи зөрүү яагаад шийдвэрлэгдээгүй үлдсэн талаар дурьдвал:

- "Монголросцветмет" ХХК-ийн хувьд уурхайн байршил нь Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд байдагтай холбоотойгоор дийлэнх хандив тусламжийг Хэнтий аймгийн ЗДТГ, Бор-Өндөр, Бэрх, Баянжаргалан зэрэг сумуудад болон нийслэлийн зарим албан байгууллагуудад өгсөн байна. Хандив тусламжийн орлого хүлээн авсан бүх аймаг сум, албан байгууллагуудад албан тоот хүргүүлсэн боловч хариу ирүүлсэн нь цөөхөн байгаагаас зөрүү шийдвэрлэгдээгүй.
- "Гоби коул энд энерги" ХХК анх Маягт №1-ийн төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэгийн хэсэгт нийт 189,788 мянган төгрөгийг тусгасанаас анхны зөрүү үүссэн. Компаниас ирсэн дэлгэрэнгүй мэдээллийг эхний байдлаар шалгахад 17,866 мянган төгрөгийг төрийн бус байгууллагад өгсөн байсныг компанийн дүнгээс хасах залруулгыг хийсэн. Компани Говь-алтай болон Баянхонгор аймгуудад хайгуул олборлолтийн үйл ажиллагаа явуулдагтай холбоотойгоор дийлэнх хандив тусламжийг тухайн орон нутгуудад хандивласан байна. Дээрхи 2 аймгуудын ЗДТГ-т албан бичиг хүргүүлсний дагуу дэлгэрэнгүй тайлбар мэдээлэл ирсэн. Энд ирсэн мэдээлэлд үндэслэн 159,572 мянган төгрөгийн ЗГ-ын дүнгээр баталгаажуулах залруулга хийснээс 12,350 мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй зөрүү үлдээд байна. Тус зөрүү нь компани хандивласан гэдгээ баталгаажуулсан боловч Говь-алтай аймгийн Төгрөг, Бигэр зэрэг сумуудын ЗДТГ-аас хандив хүлээж аваагүй гэсэн мэдэгдэл хийсэнтэй холбоотой зөрүү шийдвэрлэгдээгүй үлдсэн.
- "Шарын гол" ХК нь Дархан Уул аймгийн Шарын гол сумын ЗДТГ-т суврага босгоход 9,996 мянган төгрөг хандивласан гэсэн компанийн мэдээллийн дагуу албан тоот хүргүүлсэн. Гэтэл сумаас ирсэн албан бичигт "Засаг дарга өөрчлөгдсөн, энэ талаар мэдээлэл алга байна" гэсэн утга бүхий албан бичгийн хамт, сумынхаа 2008 оны харилцахын хуулгыг хавсаргаж явуулсан байсан. Мөн Шарын гол сумын гал унтраах анги болон Дарханы биеийн тамирын спорт хороонд тус тус 550 мянган төгрөг хандивласаныг тодруулах албан бичгүүд явуулсан боловч хариу ирээгүйгээс зөрүү шийдвэрлэгдээгүй.

Эндээс зөрүү шийдэгдэхгүй байгаа нөлөөллийг авч үзвэл:

- Хандив дэмжлэгийн орлогыг тодруулахаар явуулсан албан бичгийн хариуг ирүүлэхгүй байгаа /удаа дараа шаардсан боловч/
- Хариу захидал ирсэн боловч хүлээж аваагүй гэсэн мэдэгдэл хийсэн
- Аймаг сумуудын Засаг дарга нар өөрчлөгдсөн, аль 2008 оны талаар мэдэхгүй гэсэн тайлбар
- Зарим сум, орон нутагтай холбоо тогтооход хүндрэлтэй байдал үүссэн зэргээс зөрүү шийдвэрлэгдээгүй үлдсэн.

6.8 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал

Компаниуд	Шийдэгдээгүй зөрүүнүүд Мян.төг
<i>Компанийн төлсөн дүн ЗГ-ын тайлагнасан дүнгээс их</i>	
"Бороо гоулд" ХХК	(1,109,033)
"Монголрос цветмет" ХХК	(855,062)
"Эрдэнэт үйлдвэр" ХХК	(131,000)
"Болд төмөр ерөө гол" ХХК	(110,280)
Бусад	(14,354)
Дүн	(2,219,730)
<i>Компанийн төлсөн дүн ЗГ-ын тайлагнасан дүнгээс бага</i>	
"Цайрт минерал" ХХК	1,450,865
"Монгол газар" ХХК	99,441
"Талбулаг трейд" ХХК	30
Дүн	1,550,336

ОУИТБС-ийн тайлангийн маягтын байгаль хамгаалах үйл ажиллагааны зардал нь байгаль хамгаалах зардлын 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал болон байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Үүсээд байгаа зөрүүний учир шалтгааныг тодруулахад:

Байгаль хамгаалах зардлын 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлсэн зөрүүний дүнг тодруулахаар БОАЖЯ болон компаниуд руу албан бичиг хүргүүлсний дагуу дэлгэрэнгүй тайлангууд ирсэн ба анхны зөрүү дүнд залруулга хийсэн. Гэхдээ зарим байгууллага дэлгэрэнгүй дүнгээ ирүүлээгүй эсвэл байгаль хамгаалах 50%-ийн зардалд мөнгө шилжүүлснээр тайлагнасан байтал ЗГ-аас ирсэн дүнд байхгүй байгаагаас зөрүү шийдвэрлэгдээгүй байна. Үүнийг тодруулахаар компаниуд руу дахин албан бичиг явуулсан.

Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардлын дүнг мэдээллийн өөр өөр эх үүсвэрээс авч тайланд бөглөсөнөөс зөрүүг шийдвэрлэх ямарч боломжгүй. Өөрөөр хэлбэл ЗГ талаас тайланд тавигдсан дүнг баталгаажуулах боломжгүйтэй шууд холбоотой юм. Нэгтгэл тайлан дээр ажиллаж байгаа аудитын баг БОАЖЯ-аар дээр нэг өдөр очиж ажилласан ба уул уурхайн компаниуд жил бүр "Байгаль орчин хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"-г гаргаж өгдөг ба энэхүү 2008 оны нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын тайланг нэг бүрчлэн үзэхэд санхүүгийн тайлан бүртгэлд суурилаггүй, компанийн геологичоос гаргасан бодит бус тайлан бичдэг болох нь тогтоогдсон. Иймээс зөрүүг шийдвэрлэх боломжгүй юм.

Байгаль хамгаалах зардлын 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлсэн зөрүүний дүнг тодруулахаар БОАЖЯ болон компаниуд руу албан бичиг хүргүүлсний дагуу дэлгэрэнгүй тайлангууд ирсэн ба анхны зөрүү дүнд залруулга хийсэн. Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардлын дүнг мэдээллийн өөр өөр эх үүсвэрээс авч тайланд бөглөсөнөөс зөрүүг шийдвэрлэх ямарч боломжгүй. Энэ нь ЗГ-ын маягтны дүнг шалгахад хангалттай баримт материалууд байхгүйтэй шууд холбоотой юм. Нэгтгэл тайлан дээр ажиллаж байгаа аудитын баг БОАЖЯ-аар дээр нэг өдөр очиж ажилласан ба уул уурхайн компаниуд жил бүр "Байгаль орчин хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"-г гаргаж өгдөг ба энэхүү 2008 оны нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын тайланг нэг бүрчлэн үзэхэд санхүүгийн тайлан бүртгэлд суурилаггүй, компанийн геологичоос гаргасан бодит бус тайлан бичдэг болох нь тогтоогдсон. Иймээс зөрүүг шийдвэрлэх боломжгүй юм.

7. ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНД ӨГСӨН ХАНДИВ ТУСЛАМЖУУД (аймаг, сумд)

7.1 Хандив тусламжийн зөрүүнүүдийн шалтгаан

Компанийн өгсөн хандив тусламжийн дүн нь Засгийн газрын тайлагнасан дүнгээс 3.6 тэрбум төгрөгөөр илүү байсан. Энэхүү анхны зөрүүтэй байдал нь дараахи нөхцөл байдлын улмаас үүссэн:

- i. хандив тусламжийн дүнг сум, аймаг орон нутаг, засаг захиргааны нэгж байгууллагуудаас нэгтгэж тайлагнадаг процесс байхгүй
- ii. ОУИТБС-ийн Маягтын 1-г зүй зохистой бөглөх арга аргачлал болон мэдлэг дутмаг
- iii. маягтыг бөглөн ирүүлэх байдалд хойрго, хайнга хандах
- iv. мөн "улсын болон орон нутгийн харъяа төрийн болон төрийн өмчит байгууллагад өгсөн хандив тусламжыг тусгана" гэснийг андуурч хувийн аж ахуй нэгж байгууллага, сайн дурын холбоо, сан, төрийн бус байгууллагад өгсөн хандив болон хувь хүнд өгсөн тэтгэмж тусламж зэргийг бүгдийг нь оруулж тайлагнасан.

Үүссэн зөрүүг багасгах зорилгоор компаниуд руу дэлгэрэнгүй задаргаагаа явуулахыг хүссэн албан бичиг хүргүүлсний дагуу ирсэн дэлгэрэнгүй тайлангаас дээр дурьдсан ЗГ-ын харъяа бус байгууллага, иргэнд өгсөн хандив тусламжийг хасаж компанийн дүнд залруулга хийсэн.

ЗГ-т өгсөн хандив тусламж нэг бүрийг баталгаажуулах зорилгоор холбогдох сум, аймаг орон нутаг руу албан бичиг илгээсэн боловч хариу ирүүлсэн нь цөөхөн байна. Сум орон нутагт харилцаа холбооны хөгжил дутмагаас /үүнд: факс, интернет, утас гэх мэт/ зарим сумуудад баталгаажуулах албан бичиг хүргүүлж чадаагүй, зөвхөн утсаар холбоо тогтоож, шуудангаар ирэх мэдээ мэдээллийг нь хүлээсээр байсан.

Түүнчлэн албан ёсны хариуг ирүүлэх тал дээр хойрго хандах, цаг хугацааны хувьд давчуу, засаг дарга нь өөрчлөгдсөн, өнгөрсөн буюу 2008 оны талаар мэдэхгүй гэх мэтээр тайлбаруудыг авч байсан. Эдгээрээс үүдэн бидэнд зөрүүнүүдийг багасгахад хүндрэлтэй байлаа.

7.2 Томилолтын тайлан

Бид зарим компаний аймаг, сум, орон нутгийн байгууллага, орон нутгийн тогтвортой хөгжилд өгсөн хандив тусламжийг баталгаажуулан шалгахад Сэлэнгэ, Дархан-уул аймгуудад томилолтыг ажил хийсэн.

№	Хандив авсан байгууллагууд	Компанийн тайлангаар	Аймаг, сум, орон нутгийн байгууллагын тайлангаар	Зөрчил	Тайлбар
I	"Бороо гоулд" ХХК	1,414,346,808	1,404,887,203	9,459,605	
1	Сэлэнгэ аймгийн Засаг даргын аймаг хөгжүүлэх сан	348,247,903	348,247,900	3	
2	Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум хөгжүүлэх сан	329,000,000	329,000,000	-	
3	Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгон	14,546,000	14,546,000	-	
4	Сэлэнгэ аймгийн Мандал сумын Цагдаагийн хэлтэс	11,660,000	11,660,000	-	
	Сэлэнгэ аймгийн Мандал сумын дүн	355,233,704	355,206,000	27,704	Ханшийн зөрүү
5	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын сум хөгжүүлэх сан	321,887,821	321,887,821	-	
6	Сэлэнгэ аймгийн Баянгол суманд хөгжим	3,349,720		3,349,720	Суманд данс бүртгэлд тусгаагүй боловч Соёлын төвд уг хөгжмийг хүлээн

№	Хандив авсан байгууллагууд	Компанийн тайлангаар	Аймаг, сум, орон нутгийн байгууллагын тайлангаар	Зөрчил	Тайлбар
					авсан байна.
7	Дархан-уул аймгийн Нэгдсэн эмнэлэг	6,082,178	-	6,082,178	Албан бичгээр тайлбар авсан./2009 онд хандив авсан гэж тайлбарласан/
8	Дархан-уул аймгийн Хүүхдийн төлөө төв	24,339,482	24,339,482	-	Хүүхдийн баяраар марафон гүйлтийн тэмцээнийг ивээн тэтгэсэн хандив байсан.
II	"Болд төмөр Ерөө-гол" ХХК	138,885,300	128,748,800	10,136,500	
1	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын сум хөгжүүлэх сан	100,000,000	100,000,000	-	
2	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын оюутнуудын сургалтын төлбөр	7,500,000	7,500,000	-	
3	Сэлэнгэ аймгийн Шаамар /Дулаанхаан/ сумын сум хөгжүүлэх сан	12,229,000	12,229,000	-	
4	Дулаанхаан тосгонд мод тарих	-	5,000,000	(5,000,000)	Тосгон хөгжүүлэх сангийн дансанд уг мөнгө 2008 оны 05-р сарын 08-нд мод тарих зориулалтаар шилжүүлсэн боловч компани тайлагнаагүй байсан .
5	Сэлэнгэ аймгийн Шаамар /Дулаанхаан/ сумын оюутнуудын сургалтын төлбөр	2,572,000	-	2,572,000	Компани нь сумын дансаар дамжуулаагүй сургуулиудад шилжүүлсэн
6	Шаамар, Дулаанхаан сумын ахмадын бэлэг	680,000	-	680,000	Суманд данс бүртгэлд тусгаагүй.
7	Дулаанхаан тосгоны эмнэлэгийн зураг төсвийн төлбөр	4,000,000	-	4,000,000	Компани сумын дансанд бус зураг төслийн "Өлзий-иш" ХХК-д шууд шилжүүлсэн
8	Дулаанхаан тосгоны ахмадуудыг Утай гүнбэн явуулах зардал	3,300,000	-	3,300,000	Компани сумын дансаар дамжуулаагүй аялал жуулчлалын компанид шилжүүлсэн
9	Дулаанхаан сурын харваа	1,640,000	-	1,640,000	Суманд бүртгэгдээгүй, сурын харваа зохион байгуулсан хүн тайлан өгөөгүй байна.
10	Шаамар суманд хандив	1,000,000	1,000,000	-	
11	Дулаанхаан тосгоны баяр наадам	1,000,000	-	1,000,000	Суманд бүртгэгдээгүй, тайлан байхгүй
12	Дулаанхаан тосгоны захирагчийн алба	600,000	-	600,000	Суманд бүртгэгдээгүй, тайлан байхгүй
13	Дулаанхаан нутгийн овоо тахилга	945,500	-	945,500	Суманд бүртгэгдээгүй, тайлан байхгүй
14	Сэлэнгэ аймгийн Биеийн тамир спортын хороо	1,000,000	1,000,000	-	
15	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын өндөр настангуудад	399,000	-	399,000	Сумын дансаар дамжигдаагүй байна.
16	Ерөө сумын Бугант тосгон эмнэлэг	1,000,000	1,000,000	-	
17	Ерөө сумын Бугант				

№	Хандив авсан байгууллагууд	Компанийн тайлангаар	Аймаг, сум, орон нутгийн байгууллагын тайлангаар	Зөрчил	Тайлбар
	тосгоны сургууль	1,019,800	1,019,800	-	
III	"Хунан жинлэн" ХХК	4,750,000	4,500,000	250,000	
1	Сэлэнгэ аймгийн Ерөө сум	4,500,000	4,500,000	-	
2	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Эмнэлэг	250,000	-	250,000	Сумын эмнэлэг энэ талаар мэдэхгүй, данс бүртгэл, тайланд тусгагдаагүй
IV	Зүрийн булан ХХК	1,250,000	-	1,250,000	
1	Сэлэнгэ аймгийн Ерөө сум	1,000,000	-	1,000,000	Суманд энэ талаар мэдэхгүй байна.
2	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Эмнэлэг	250,000	-	250,000	Сумын эмнэлэг энэ талаар мэдэхгүй, данс бүртгэл, тайланд тусгагдаагүй
V	Жамп ХХК	200,000	200,000	-	
1	Сэлэнгэ аймгийн Ерөө сум	200,000	200,000	-	
VI	Эрдэс холдинг ХХК	1,400,000	500,000	900,000	
1	Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар	500,000	500,000	-	
2	Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгон	900,000	-	900,000	Тосгоны данс бүртгэл, тайланд тусгагдаагүй
VII	Шарын гол ХХК	25,500,000	25,000,000	500,000	
1	Дархан-уул аймгийн Биеийн тамир спортын хороо	500,000	-	500,000	Дарга, нягтлан бодогч нь байхгүй. Хандивийн талаар сум орон нутгийн засаг захиргааны байгууллагаас үзэх тайлан байхгүй.
2	Дархан-уул аймгийн Лха телевиз	25,000,000	25,000,000	-	Зээл төлсөн.
VIII	Эрэл ХХК	866,500	866,500	-	
1	Дархан-уул аймгийн Засаг даргын тамгын газар	866,500	866,500	-	
	Нийт дүн	1,587,198,608	1,564,702,503	22,496,105	

Шалгалтанд нийт 8 компаний 2 аймгийн 6 сум, тосгон, 35 нэгжид өгсөн хандив тусламжийг хамруулсан. Шалгалтанд хамрагдсан аймаг, сум, байгууллагуудын хандив, тусламжийн тайлан 22,496.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан байсан.

Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал, Баянгол сумдууд хандив, тусламжийн хөрөнгөөр орон нутагтаа бүтээлч ажил хийсэн ба бүртгэл тайландаа тусгасан.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны Тосгон хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүртгэл хангалтгүй, зарцуулалт нь сайн биш байна. Тухайлбал: Дулаанхаан тосгон энэ сангаас 1 хувийн хүүтэй 8,6 сая төгрөгийн зээлийг иргэдэд өгсөн гэж мэдээ гаргасан боловч зээлийг данс бүртгэлд хэрхэн тусгасан, зээл хүүгийн төлбөрийг хэрхэн төлүүлж байгаа нь тодорхойгүй байна.

Мөн энэ сангаас өндөр үнэтэй хуучин машин худалдаж авсан. /STANA маркийн машиныг 7,5 сая төгрөгөөр/ Энэ машин ажилладаггүй, эвдэрсэн байна.

7.3 Нийтлэг дутагдал

Бидний ажлын явцад дараахи нийтлэг дутагдлууд ажиглагдсан: Үүнд:

1. Компаниуд хандив тусламжийг бэлэн болон бэлэн бусаар өгдөг боловч хандив хүлээн авагч байгууллага, аймаг, сумд энэ хөрөнгө оруулалтыг бүртгэл тайландаа бүрэн оруулдаггүй, зөвхөн харилцах дансаар шилжиж орсон мөнгийг бүртгэдэг байна. Аймагт нэгдсэн тайлан гаргадаггүй, хандивласан хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт байхгүй эсвэл хийдэггүй байна. Тухайлбал: Сэлэнгэ аймгийн Дулаанхаан тосгон, Ерөө суманд "Болд төмөр-Ерөө гол" ХХК-иас бэлэн мөнгөөр олгосон нийт 5,264.5 мянган төгрөгийн хандивийг тайлагнаагүй байсан. Мөн Сэлэнгэ аймгийн Баянгол суманд "Бороо гоулд" ХХК-аас хандивласан 3,349.7 мянган төгрөгийн хөгжмийг бүртгэж тайлагнаагүй байна. Дархан-уул аймгийн Шарын гол сумын захиргааны удирдлагууд солигдсон учир "Шарын гол" ХХК-иас 2008 онд хандивласан хөрөнгийн тайланг гаргах боломжгүй гэж засаг дарга нь бидэнд албан бичиг хийж өгсөн.
2. Олборлох үйлдвэрүүдийн гаргасан тайлан шаардлага хангахгүй, маягтаа ойлгохгүй буруу тайлагнадаг байдал нь нягтлан бодогч нар нь их солигддогоос болж, шинээр ажилд орсон хүн нь ажлаа мэдэхгүй буруу тайлан гаргах зэргээр хүндрэл учруулж байна. Тухайлбал: "Бороо гоулд" ХХК-ийн тайлангаар Дархан-уул аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хүүхдийн төлөө төвд олгосон гэж тайлагнасан хандивийн нийт 30,421.6 мянган төгрөгийг газар дээр нь очиж шалгахад Нэгдсэн эмнэлэгт тухайн онд /2008/ хандив олгогдоогүй, мөн Хүүхдийн төлөө төвд бус харин хүүхдийн баяраар Дархан-Уул аймагт зохиогдсон марафон гүйлтийн тэмцээнийг ивээн тэтгэсэн байсан. "Болд төмөр-Ерөө гол" ХХК-ийн тайланд тусгагдаагүй 5,0 сая төгрөгийн мод тарих хандивийн мөнгө "Дулаан хаан" тосгоны хөгжлийн сангийн дансанд орсон байна.

8. АСУУДЛУУД

8.1 Тайлан гаргахад хойрго ханддаг байдал

Биднийг нэгтгэлийн ажлаа бүрэн хийхэд анхны өгөгдсөн мэдээлэл болон тэдгээрийг батлах, дэлгэрэнгүй мэдээлэлээр хангах байдалд компаниуд хойрго хандаж байсан.

Тухайлбал, "Тэн хүн" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч А.Өлзийжаргал нь ОУИТБА-ийн албанд 2008 оны тайлангаа гаргаж өгөөгүй. Бидний зүгээс нэгтгэл тайлангийн ажил эхлэх үед буюу 2010 оны 3 сарын 25-ны өдөр энэхүү компанийг оролцуулан бүх компаниуд руу албан бичиг хүргүүлсэн ба албан бичгийн хариугаа ирүүлэхгүй удаа дараа утсаар ярьж шаардсан боловч үл ойшоож "энэ бол сайн дурын ажил тайлангаа өгөх өгөхгүй нь бидний асуудал"..., өгсөнгүй гээд бидэнд хариуцлага тооцох хуулийн заалт байхгүй гэж" утсаа тасалж байсан. Мөн "Таван толгой", "Коулд гоулд монгол" ХХК-иудын ерөнхий нягтлан бодогч нар нь дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэхгүй хойрго хандсан, "Гацуурт" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч нь өөрчлөгдсөн, "Петро чайна дачин тамсаг" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч өвчтэй байсан ба, мөн 2008 оноос хойш ажилд орсон тэр үеийн зүйлийг мэдэхгүй гэх мэт шалтаг, шалтгаан тоочиж байсан, "Монполимет" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч удаан хугацаагаар гадаад руу ажлаар явсан, тооцооны ня-бо нар нь сайн мэдэхгүй гэсэн хэдий ч, нилээд шаардуулсаны эцэст гаргаж өгсөн.

Харин нэгтгэл тайлангийн ажилд идэвхи санаачлага гарган ажиллаж, бидний шаардсан мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж ирүүлсэн "Монголросцветмет", "Монголын алт МАК", "Шижир алт", "Болд төмөр ерөө гол", "Чинхуа МАК нарийн сухайт", "Дацан трейд", "Тефис майнинг", "Гоби коул энд энерги" зэрэг компаниудыг онцлон дурьдмаар байна.

8.2 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар

БОАЖЯ-наас байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардлын зөрүүг тохируулах үүднээс компаниас ирүүлсэн дүнг Байгалийн нөөцийн газарт компанийн "Уул уурхай байгаль орчин мэдээллийн тайлан, төлөвлөгөөний үзүүлэлтүүд" /БОХ-3/ гэсэн маягтаар тайлагнасан тоон үзүүлэлтэд үндэслэн тохируулах ажлыг гүйцэтгэсэн боловч бидний хүссэн хэмжээний тулган баталгаажуулалт

болж чадсангүй. Учир нь уг тайланг компаниудын геологчид, уул уурхайн инженер техникийн ажилтнууд гаргаж, БОАЖЯ-нд ирүүлдэг ба тоон үзүүлэлтийг санхүүгийн тайлангаар гарсан зардалд үндэслэн гаргадаггүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй төлөвлөсөн ажлаа гүйцэтгэсэн мэтээр хийсвэр тоо мэдээгээр тайлагнадаг нь тухайн тайлангаас харагдсан учраас энэ зөрүүг шийдвэрлэж чадахгүйд хүрсэн. Эдгээр нөхцөл байдлуудын улмаас, зөрүүнүүдийг шийдвэрлэх бололцоогүй байсан.

8.3 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр нь ам.доллараар төлөгддөг. Маягтыг бөглөх заавар ёсоор, оролцогч талууд нь мэдээллийг ам.доллараар ирүүлэх хэрэгтэй байдаг. Харин компаниуд Маяг №1-г бэлтгэхдээ ам. долларыг төгрөгт хөрвүүлэн зөрүүтэй бэлтгэж байна. Гэтэл ЗГ-ын талаас Маягт №2-ыг бөглөхдөө төлсөн валютаар нь бөглөж ирүүлж байгаа нь зөрүү үүсэхэд нөлөөлж байна.

8.4 ЗГ-ын гаргасан тайлан нь бүрэн бус байгаа талаар

ЗГ-ын тайланд хандив, тусламжийн дүн ихэнхдээ дутуу тусгагдаж байна. Энэ нь орон нутагт төлөгдсөн татвар, төлбөр, хураамжууд УТЕГ-т бүрэн мэдээлэгдэхгүй байгаатай холбоотой байна. Мөн хандив тусламжийг ЗГ-ын тайланд бүрэн хамруулах үр дүнтэй тогтолцоо харагдахгүй байна.

Улсын төсвөөс санхүүждэг байгууллагууд нь хэрэв мөнгөн болон мөнгөн бус хандив тусламж авсан бол нягтлан бодох бүртгэлдээ хандив тусламжийн орлогоор бүртгэн, санхүүгийн тайландаа тусгах ба санхүүгийн тайлан нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад орон, ЗГ-ын нэгдсэн тайланд нэгтгэгддэг.

Эндээс Сангийн яам нь хандив тусламжийн дүнг нэгтгэн гаргах боломжтой юм.

8.5 Хураамж, үйлчилгээний шимтгэл

Компаниудын төлсөн хураамж үйлчилгээний хөлс нь ЗГ-ын тайланд төдийлөн бүрэн тусгагдахгүй байна. Маш олон төрлийн хураамж, шимтгэл янз бүрийн газарт төлөгддөг бөгөөд жижиг дүн бүхий их хэмжээний гүйлгээ гардаг байдал нь нэгтгэл хийхэд хүндрэлтэйгээс гадна одоогоор энэ бүгдийг нэгтгэн ЗГ-ын тайланд оруулах нөхцөл бололцоо нь хязгаарлагдмал байна.

Уул уурхайн компаниуд дараахи хураамж, үйлчилгээний шимтгэлүүдийг төлдөг. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын газарт жин баталгаажуулалтын хөлс, хэмжилтийн хөлс
- Орон нутгийн төсөвт болон тээврийн үйлчилгээний газарт тээврийн ариутгалын төлбөр, DC зөвшөөрлийн бичиг
- ХХҮГ болон орон нутгийн төсөвт гадаад иргэдийг олон удаа орох гарах визний хуудас, үйлчилгээний хөлс, оршин суух зөвшөөрөл, тодорхойлолтын үнэ, хөдөлмөр эрхлэлтийн урилга,
- АМГ-т лицензийн үйлчилгээний төлбөр, бүртгэлийн төлбөр, тайлангийн үйлчилгээ, геологийн багц мэдээллийн хөлс, талбайн захиалгын захиргааны хөлс, лиценз худалдан авах үйлчилгээний хөлс, тайлан хянуулах хөлс
- БОАЖЯ-нд тусгай зөвшөөрлийн хөлс,
- Замын цагдаагийн газарт үнэмлэхний хураамж, үзлэгийн хураамж
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд тэмдэгтийн хураамж
- Усны хэмнэлтийн төвд үйлчилгээний хөлс
- Улсын нийгмийн даатгалын ерөнхий газарт лавлагаа гаргуулсаны хураамж
- Сорьцын албанд сорьцын шинжилгээний зардал
- Орон нутгийн газрын албанд гэрчилгээний үнэ
- Стандарт хэмжил зүйн төвд нарийн хэмжүүрийн хөлс, стандартын үйлчилгээний хөлс
- Татварын албанд зөвшөөрлийн хөлс

8.6 Бүртгэлийн ажилтны ур чадвар, чадавхи

Бүх компаниудын хувьд ОУИТБС-ийн тайланг бөглөсөн дүн болон дараа нь дэлгэрэнгүй задаргаагаар ирүүлсэн дүн хоорондоо таарахгүй байгаа нь нягтлан бодогчдын ур чадвар дутмаг, эсвэл тайланг бөглөхдөө үл ойшоосон байдлаар хандах байдал нь зөрүү үүсэхэд нөлөөлж байна.

8.7 Харилцаа холбооны бэрхшээл

Энэхүү ОУИТБС-ын 2008 оны нэгтгэл ажлыг гүйцэтгэх явцад хандив тусламжийн орлогыг ЗГ талаас баталгаажуулах боломжгүй байсан, учир нь ЗГ-ын харъяа төсөвт болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудаас хандив, тусламжийн дүнг нэгтгэж тайлагнадаг тогтолцоо байхгүй, алслагдсан сум орон нутагт мэдээлэл харилцаа холбоо муу хөгжсөн зэргээс шалтгаалан дэлгэрэнгүй мэдээлэл олж авах боломжгүй байлаа. Мөн аль 2008 онд болж өнгөрсөн үйл явцыг мэдэхгүй, хариуцсан албан тушаалтан, Засаг дарга нар өөрчлөгдсөн зэрэг нь нэгтгэлийн ажилд хүндрэл учруулж байсан.

9. ЗӨВЛӨМЖҮҮД

Бидний зүгээс ОУИТБС-ын АХ нь ОУИТБС-ыг хуульчлах ажлын хэсгийг байгуулан, маягтуудын өгөгдлүүд, мэдээллийг цуглуулах байдлыг хянах, түүнчлэн бидний энэхүү тайланд дурьдагдсан асуудлууд болон зүйлсийн талаар хэдийнээ ажил хэрэг болгож, авах арга хэмжээнүүдийн талаар тодорхой хэмжээний ажлуудыг хийж эхэлсэн байгааг мэдэж байгаа билээ. Мөн АХ нь ОУИТБС-ын талаар дэлгэрүүлэх, таниулах ажлын хүрээнд Улаанбаатар хотноо хэд хэдэн удаагийн сургалт, семинаруудыг зохион байгуулсан байна.

Хэдий тийм ч бидний зүгээс өөрсдийн хийсэн ажлын хүрээнд ажиглагдаж, илрүүлсэн зүйлсийнхээ дагуу зохих зөвлөмжүүдийг өгч байгаа ба эдгээр зөвлөмжүүд маань Монголын ОУИТБС-ын хэрэгжилт, түүний сайжруулалтад тус нэмэр үзүүлэх ёстой.

9.1 ОУИТБС-ын үйл явц болон үүний гүйцэтгэлийг албан болгох шаардлага

а. Монголын ОУИТБС-ын зорилго, үйл ажиллагааг хуульчлах тухай

Монгол улсын парламент Монголын ОУИТБС-ын элементүүд, түүний зарчмуудыг хуульчлан баталж, холбогдох яамны зүгээс тодорхой дэлгэрэнгүй мөрдөөх заавар, журам, дүрмийг гаргах нь зүйтэй. Үүнтэй уялдан, шаардлага нөхцлийг биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог мөн бүрдүүлж өгөх нь зохистой.

б. Хугацааг товлож, хэвлэн нийтлэх тухай

Цаг хугацааны хувьд доорхи зүйлсийг багтаах нь зүйтэй.

- Нэгтгэлийн ажлыг гүйцэтгэх Хараат бус нэгтгэгч буюу зөвлөхийг сонгох цаг хугацаа
- Хамрагдах компаниудын маягтаа ирүүлэх цаг хугацаа
- Нэгтгэлийн ажлыг гүйцэтгэх цаг хугацаа
- Нэгтгэлийн ажлын явцад илэрсэн зүйлсийг тайлагнах цаг хугацаа
- Нэгтгэлийн тайланг олон нийтэд мэдээлэх, нийтлэх цаг хугацаа зэрэг болно.

в. ОУИТБС-ын маягт дахь орлогын үзүүлэлт нэг бүрийн тодорхойлолтыг улам сайжруулж, боловсронгуй болгох

Орлогын үзүүлэлт нэг бүрийн хамрах хүрээ, тодорхойлолтыг гаргах. Энэ нь маягтыг зөв зүйтэй бөглөхөд үүсдэг эргэлзээ, тээнгэлзээг арилгахад тус дөхөм болно.

г. Компаниудын ОУИТБС-ын маягтаар хүргүүлэх мэдээлэл нь нэгтгэлийн баталгаатай уялдсан байх тухай

Компаниудын зүгээс ОУИТБС-ын шаардлагын дагуу хүргүүлэн ирүүлж буй мэдээлэл нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдэж, аудитаар баталгаажсан тайлантай уялдсан байх хэрэгтэй.

Түүнчлэн, хамгийн бага хэмжээний дүнг тогтоох тал дээр анхаарах нь зүйтэй. Үүний үр дүнд, тогтоосон хэмжээнээс доогуур хэмжээний төлбөр төлсөн компаниудыг нэгтгэлд хамруулахгүй байх, зарим талаараа ОУИТБС-ын хувьд нийт орлогын хэмжээнд материаллаг бус дүнтэй жижиг байгууллагуудын хувьд дарамт шахалт үзүүлэхгүй байх болно.

д. Засгийн газрын ОУИТБС-ын мэдээ, мэдээллийг цуглуулах болон тайлагнах үйл явц нь тодорхой хугацаанд аудитлагдаж байх шаардлагатай

Өнөөгийн байдлаар ОУИТБС-ын үйл ажиллагааны хүрээнд ЗГ-ын үйл явцыг аудитлах тухай ямарваа нэгэн зүйл заалт байхгүй байгаа билээ. Тодорхой нэгэн хугацаанд давтамжтайгаар хянан шалгаж байх нь эдгээр үйл явц, процессуудыг сайжруулах, тэдгээрийг илүү үр дүнтэй явагдахад нөлөөлнө (2008 оны Нэгтгэлийг хийх явцад энэхүү үйл явцтай уялдан тулгарсан хүндрэл, бэрхшээлийн талаар Бүлэг 6-с уншина уу).

9.2 МОУИТБС-ын АХ нь ОУИТБС-ын тайлан мэдээнд оруулж буй төлбөр болон орлогыг хянан үзэх шаардлага

Энэхүү шаардлагын хүрээнд газрын тосны болон уул уурхайн компаниудын хийсэн материаллаг төлбөр болон хүлээн авсан орлого бүгд багтсан гэдгийг хянан шалгаж, нотлох байдлыг үүсгэж болно. Тиймээс, бидний зүгээс дараахи орлого/төлбөрүүдийг анхааран үзэх нь зүйтэй гэж зөвлөж байна.

а. Дэд-гүйцэтгэгч нарын тухайд

Монгол улсад зарим уул уурхайн компаниуд өөрийн уул уурхайн үйл ажиллагааг гүйцэтгүүлэх үүднээс дэд-гүйцэтгэгч нартай гэрээ байгуулан ажиллуулдаг. Жишээлбэл, өрөмдлөг, хөрс хуулалт, нөхөн сэргээлт зэрэг нь олборлох үйл ажиллагаатай шууд холбоотой юм.

Тухайн дэд гүйцэтгэгч нар нь ОУИТБС-ын ажлын хэсгийн шалгуураар сонгогдсон компанийн ажлыг хамтран гүйцэтгэж байгаа учир тус дэд гүйцэтгэгчийн ЗГ-т төлсөн төлбөрийг ОУИТБС-ын тайланд оруулах ёстой.

Тиймээс бидний зүгээс, АХ нь энэ талаар шийдвэр гарган уул уурхайн компаниудын дэд-гүйцэтгэгч нарыг ОУИТБС-д багтаах, түүнчлэн боломжтой бол маягыг бөглүүлэн ирүүлэхийг шаардах хэрэгтэй.

б. Хандив, тусламжийн тухайд

Компаниудын тайлагнан ирүүлсэн хандив тусламжийн дүнгүүд нь ихэнх тохиолдолд ЗГ-т өгсөн бус харин сайн дурын болон нийгэм, олон нийтийн ашиг тусын (барилга, зам, дэд бүтэц гэх мэт) тулд өгсөн зардлуудыг харуулж байгаа билээ.

Тиймээс АХ нь дараахи зүйлс дээр анхаарах нь зүйтэй хэмээн зөвлөж байна.

- i. ОУИТБС-ын хандив, тусламжийн хүрээнд хамруулах зүйлсийн тодорхойлолтыг хянан үзэж, ЗГ-т төлөгдөөгүй дүнг оруулахгүй байх эсвэл сайн дурын үндсэн дээр тайлагнахыг компаниудаас шаардах,
- ii. Хандив, тусламжийг тайлагнах тал дээр хамгийн бага дүн хэмжээг тогтоож болох эсэхийг судлах.

в. Хураамж, үйлчилгээний шимтгэлийн тухайд

2008 оны хувьд нийт залруулагдсан орлого болох 685 тэрбум төгрөгийн 2.5 тэрбум төгрөг нь ЗГ-ын нийт тайлагнасан хураамж, үйлчилгээний шимтгэл юм. Эдгээр шимтгэлүүд нь энэ удаагийн ОУИТБС-д хамрагдсан ЗГ-ын нийт хүлээн авсан дүнгийн зөвхөн 0.36%-г эзэлж байгаа ба энэ нь үнэхээр олборлох салбарын тайлагнагдах материаллаг орлого болох эсэх талаар АХ анхааран үзэх хэрэгтэй.

г. Байгаль орчин хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын тухайд

Эдгээр зардлууд нь компаниудын зүгээс тайлагнагдсан хэдий ч ЗГ-ын байгууллагуудад төлөгдөөгүй, харин орон нутгийн гэрээлэгч талуудад төрөл бүрийн ажил гүйцэтгэсний хувьд төлөгдсөн. Тиймээс доорх байдлуудын улмаас ямар нэгэн нэгтгэл хийгдэх нөхцөл үүсэхгүй байна. Үүнд:

- а. Компаний зүгээс СЯ болон ОУИТБС-ын зөвлөх нарт ирүүлсэн зардлын дүн;
- б. ЗГ нь компаниудын ирүүлсэн дүнд үндэслэн тайлагнасан болохоос яг бодитоор хүлээж авсан дүн биш юм.

Энэ нь хараат бус нэгтгэл болж чадахгүй байгаа юм. Тиймээс, эдгээр зардлуудыг нэгтгэх бус харин ОУИТБС-ын маягтын Хамрах хүрээ 2 буюу Ашиг орлогын урсгал хэсэгт оруулах нь зүйтэй хэмээн зөвлөж байна. Нийт шийдэгдээгүй зөрүүнүүдийн 2/3-г энэ төрлийн зардал эзэлж байгаа билээ.

БОАЖЯ-нд компаниудаас жил бүр ирүүлдэг "Байгаль Орчиныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"-гийн зарцуулалтын дүнгүүд нь компанийн санхүүгийн ажилтан болон санхүүгийн мэдээлэлтэй уялдалгүй техникийн талын ажилтан бэлтгэдэг болохыг бид ажигласан. Тэгэхээр тайлагнасан зардал нь яг компаний зардлын бүртгэлийн баримт материалд тулгуурлаагүй тайлагнагдсан байгаа юм. Цаашид, нэгэнт эдгээр тайлангууд нь компанийн зүгээс хийх ёстой байгаль орчны зарцуулалтын бодит байдалд хяналт тавихад үндсэн суурь болдог тул БОАЖЯ-ны зүгээс цаашид шалгалтыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

9.3 МОУИТБС-ын АХ нь компаниудын төлсөн дүн болон ЗГ-ын хүлээн авсан дүн хоорондын зөрүүний алдааны хүлээн зөвшөөрөгдөх түвшинг тогтоох шаардлага

АХ-ийн зүгээс үүссэн зөрүүнүүдийг шалгахад ашиглагдах материаллагын түвшингийн зааврыг гарган хангаж өгөх нь зүйтэй. Энэ нь нэгтгэлийн ажлын үр ашгийг нэмэгдүүлж, улмаар ажлын үр дүнд хүрсэн дүгнэлтүүдийг нилэнхүйд нь хамралгүй харин онцолсон бүлэг буюу анхаарал татсан дүнд илүү хүч хөдөлмөр зарцуулан ажилласнаар мөнгөний үнэ цэнийг нэмэгдүүлэх болно.

Тухайлбал, хандив тусламжийн дүнг шинжлэн үзэхэд бидний хувьд ихээхэн сонирхолтой байлаа. Учир нь 2008 оны хувьд маягтаар давхардаагүй тоогоор нийт 256 удаагийн нийт 11.5 тэрбум төгрөгийн санхүүгийн дүн бүхий хандив тусламжууд анхлан компаниудын зүгээс тайлагнагдсан. Эдгээрийн дунд 38 удаагийн хандив, тусламжийн дүн нь нийтдээ 11.0 тэрбум төгрөг болж байсан. Эдгээр 38 удаагийн хандивын аль нь ч дангаараа 10 сая төгрөгнөөс бага байгаагүй. Өөрөөр хэлбэл, нийт тайлагнагдсан дүнгийн 95% нь эдгээр 38 удаагийн хандив буюу 10 сая төгрөгнөөс илүү дүнтэй хандив тусламжаас бүрдэж байсан.

9.4 Шийдэгдээгүй зөрүүнүүдийг шалгах шаардлага

Шийдэгдээгүй зөрүүнүүдийн талаар нилээн хүч хөдөлмөр гарган ажиллаж ЗГ-ын нийт хүлээн авсан дүнгийн 0.16%-г болтол нь бууруулсан хэдий ч мэдээлэл болон тайлбаруудыг цуглуулан авч, бүх зөрүүнүүдийг шийдвэрлэх боломжгүй байлаа. Тиймээс АХ нь цаашид энэ талаар хэрхэх тухай анхааран үзэж, зохих арга хэмжээ авах нь зүйтэй.

9.5 Хамрагдсан компаниудтай харилцах болон тэдгээрийн ажиллагсадыг сургах шаардлага

ЗГ-ын харъяа, яам агентлагууд, орон нутгийн засаг захиргаа болон компаниудын хувьд маягтанд ямар төрлийн мэдээллийг оруулах, хэрхэн бөглөх талаархи ойлголт ерөнхийдөө дутмаг хангалтгүй байсан.

Энэ байдал нь хангалтгүй бэлтгэгдсэн маягтуудын дүнгээс болон зөрүү үүсэх түүнчлэн, нэгтгэлийн үйл явцыг хүндрүүлж байлаа.

Тиймээс, бидний зүгээс ОУИТБС-ын дагуу тайлагнагдсан орлого болон төлбөрүүдийн нэгтгэлийн үйл явцыг сайжруулах мөн ОУИТБС-ын тухай мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхийн тулд үргэлжилсэн сургалт, семинаруудыг газарзүйн байршил болон тохирох орчинд нь явуулах, түүнчлэн, ОУИТБС-ын тайлагналын шаардлага, уялдах мэдээ, мэдээллээр хангах үйл явцыг сайжруулан дээшлүүлэх зэргийг дэмжих шаардлагатай.

9.6 ЗГ-ын зарим агентлагуудын систем болон анхан шатны мэдээллүүд бүрдэлтийг сайжруулах шаардлага

а. Үндэсний татварын ерөнхий газар

Анхлан тайлагнагдсан дүнд хийгдсэн залруулгуудын хэд хэд нь УТЕГ-аас ирүүлсэн дүн нь илт буруу зөрүүтэй тайлагнагдсаны улмаас хийгдсэн. Хүлээн авсан орлогуудын талаар бүрэн дүүрэн найдвартай мэдээллүүдийг авах үүднээс олон удаагийн уулзалт, ярилцлагуудыг УТЕГ-тай хийсэн ч анхны мэдээлэл хаанаас бүртгэгдсэн болон зөрүүний хувьд хангалттай тайлбаруудыг авч чадаагүй. Тухайлбал, УТЕГ нь нэгэн компаний төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ("роялти төлбөр")-ийн хүлээн авсан нийт дүнг 7.35 сая төгрөг хэмээн тайлагнасан нь компанийн тайлагнасан дүнгээс 3.38 сая төгрөгөөр бага байсан.

УТЕГ-с сүүлд нь ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу нийт дүн нь 10.73 сая төгрөг буюу компанийн тайлагнасан дүнтэй адил ирсэн. УТЕГ нь энэхүү анхлан ирүүлсэн дүн болон дэлгэрэнгүй мэдээлэл хооронд гарсан зөрүүнийхээ шалтгаан эсвэл анхлан тайлагнагдаагүй үлдсэн байдлыг бүрэн дүүрэн тайлбарлаж чадаагүй.

6. Аймаг, сумд

Аймаг, сумдын албан тушаалтангуудаас мэдээлэл авах үед өмнөх жилүүдэд гарч байсан хүндрэлүүд мөн давтагдаж байсан ба ялангуяа, хандив тусламжийн хувьд анхлан тайлагнагдсан 1.0 тэрбум төгрөг нь нэгтгэлийн явцад 4.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

Аймаг сумдын түвшинд орлого болон зарцуулалтын бүртгэх байдал болон системийг шалган үзэх хэрэгтэй ба тэгснээр ЗГ нь орлого бүрэн дүүрэн бүртгэгдсэн болон зарцуулалт нь зүй зохистой явагдсан гэдгийг төсвийн түвшинд найдвартай байлгаж чадна.

9.7 Бусад зөвлөмжүүд

а. Компанийн аудитлагдсан санхүүгийн тайланд ОУИТБС-ын хүрээнд тайлагнасан мөнгөн урсгалын тайлан мэдээ бүхий тодруулгыг багтаах тухай

Энэхүү тодруулга нь мөнгөн сууриар бэлтгэгдэх ба санхүүгийн тайланд оруулсан тоон үзүүлэлтүүдтэй уялдаж компанийн хараат бус аудиторын гаргасан дүгнэлтэнд хамрагдсан байх хэрэгтэй.

б. Уул уурхайн болон газрын тосны компанийг МОУИТБС-д тусгайлан авч үзэх боломжийг судлах тухай

Уул уурхайн болон газрын тосны салбар хооронд ижил төстэй зүйлс байх хэдий ч тус бүрийн журам, дүрэм болон гэрээний нөхцөл байдлын үед ялгаатай хандах зүйл байдаг.

АХ энэхүү байдлуудыг үнэлэн дүгнэж шаардлагатай гэж үзсэн өөрчлөлтүүдийг дараа дараагийн нэгтгэлийн ажилд оруулах нь зүйтэй.

в. Харилцаа холбооны тухай

Монгол улсын хувьд яам, агентлагууд нь орон нутагтайгаа холбоо барих үед харилцаа холбооны найдваргүй байдлаас болж, ялангуяа, цахилгаан хэлбэрээр /и-мейл/ харилцаа тогтооход хүндрэлтэйн улмаас мэдээлэл дамжуулахад хэцүү төвөгтэй болдог. Энэ байдал нь мэдээллийн урсгалыг удаашруулж ярвигтай болгохын дээр шуудан холбоогоор мэдээ, мэдээлэл илгээж явуулах тохиолдолд алдагдах болон хасагдах нөхцөл үүсдэг. Үүнийг сайжруулах үүднээс, цахилгаан шуудангийн системтэй болгох, эсвэл, дундын цахилгаан мэдээллийн баазтай болгох зэрэг дээр анхаарах нь ажлын үр дүнг сайжруулах үр дүнтэй.

10. ХАВСРАЛТУУД

- А. Нэгтгэлийн дүнд үүссэн залруулгууд (2) – санхүүгийн урсгалаар
- Б. Нэгтгэлийн дүнд үүссэн залруулгууд (2) – компаниар
- В. Мэдээллийн эх сурвалжууд - Засгийн газрын байгууллагууд
- Г. Компаниудын жагсаалт
- Д. Удирдлагын хариуцлагын захидлууд
- Е. Уулзан, ярилцсан хүмүүс
- Ж. Оролцогч талууд
- З. Оролцогч талуудын мэдээлэл
- И. Анхны зөрүүнүүдийн хүснэгтүүд
- К. Нэгтгэлийн дүнд үүссэн цэвэр залруулгануудын хүснэгтүүд
- Л. Шийдэгдээгүй зөрүүнүүдийн хүснэгт
- М. Компаниудаас өгсөн хандив, дэмжлэгийн товчоо

Хавсралт А - Нэгтгэлийн дүнд үүссэн залруулгууд (1) – санхүүгийн урсгалаар

Тайлангийн Бүлэг 5.1-д маягтуудаар анхлан ирүүлсэн санхүүгийн урсгалуудын нийт дүнг харуулсан. Энэхүү хавсралт нь Монголын ОУИТБСАА-аас тогтоосон маягтуудын дагуу анхлан ирүүлсэн дүнд хийсэн залруулгуудыг дүрслэн харуулж байгаа болно.

1. Татварууд

Анхлан ирүүлсэн маягтууд дахь татварууд хэсгийн зөрүүнүүд болон нэгтгэлийн үр дүнд засгийн газрын нэгж байгууллагууд, компаниудаас ирүүлсэн дүнд хийсэн залруулгуудыг дараахи байдлаар харуулав. Үүнд:

Бүлэг	Анхны зөрүүнүүд, цэвэр	Залруулагдсан байдал Засгийн газрын нэгж байгууллагууд		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Компаниуд		
	мян.төг	мян.төг	мян.төг	
1.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	19,644,800	528,280	20,168,943	4,137
1.2 Гаалийн албан татвар	(20,076,011)	-	(20,135,838)	59,827
1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	(9,460,508)	32,021	(9,428,487)	(-)
1.4 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	(203,487)	225,192	18,225	3,480
1.5 Онцгой албан татвар (шатах тослох материал импортолсон бол)	807,210	-	807,210	(1)
1.6 Автобензин, дизелийн түлшний албан татвар	(73,801)	-	(73,801)	-
1.7 Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	(13,330)	36,152	17,477	5,345
1.8 Мөнгөн дүнгээрх бусад татварууд (1)	(6,729,772)	52	(6,729,720)	-
1.9 Мөнгөн дүнгээрх бусад татварууд (2)	(72,672)	138	(72,534)	-
Нийт	(16,177,571)	821,835	(15,428,524)	72,788

1.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр	Залруулагдсан байдал Засгийн газрын нэгж байгууллагууд		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр
		Компаниуд		
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	19,644,800	528,280	20,168,943	4,137

ААНОАТ-ын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь анхны тайландаа өөр татварын төрлөөр харилцан суутгал хийсэн татварын дүнг бүрэн тайлагнаагүй байсан.
- “Бороо гоулд” ХХК-ийн зээлийн хүүгийн орлогоос суутган тооцсон татварыг ЗГ тайлагнаагүй.
- “Цайрт минерал” ХХК нь ногдол ашгийн болон гадаадад шилжүүлсэн орлогоос суутгасан татварыг бусад татвар хэсэгт тайлагнасан.
- “Анхай интернэйшнл” ХХК-ийн 10 дугаар сарын 31-нд төлсөн 1,228.8 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн албан татварыг ЗГ анхны тайландаа дутуу тусгасан.
- “Уулс заамар” ХХК анхны тайландаа уг татварыг төлсөн талаар тусгаагүй ба дэлгэрэнгүй мэдээллээр төлсөн гэж тайлагнасан.
- “Эрэл” ХХК нь 2007 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлөөгүй үлдэгдлийн 2008 онд төлсөн дүнгээ анхны тайландаа тусгаагүй байсан.

- “Адамас майнинг” ХХК нь анхны тайландаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлсөн дүнг тайландаа тусгаагүй байсан нь дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон.
- ЗГ анхны тайландаа “Айвенхоу майнз монголия инк” ХХК-иас хүлээн авсан татварыг бүрэн тусгаагүй дутуу тусгасан нь дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон ба компани тайланг мөнгөн сууриар бус аккрузал сууриар бэлтгэсэн.
- “Чинхуа МАК нарийн сүхйт” ХХК нь анхны тайландаа ногдол ашгийн татвар болон НӨАТ-ын буцаалтаас суутган тооцсон татвар зэргийг бусад татвар хэсэгт тайлагнасан.

1.2 Гаалийн албан татвар

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр мян.төг	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Гаалийн албан татвар	(20,076,011)		(20,135,838)	59,827

Гаалийн татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- Компаниуд нь ихэвчилэн гаальд төлсөн НӨАТ, онцгой албан татвар, авто бензин дизелийн түлшний албан татвар, гаалийн бүрдүүлэлтийн хураамж зэргийг бүхэлд нь тайлагнасан учраас залруулгыг ГЕГ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн хийсэн.

1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар (ЗБҮӨАТ)

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр мян.төг	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	(9,460,508)	32,021	(9,428,487)	-

ЗБҮӨАТ-ын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 12 дугаар сарын 31-нд төлсөн дүнг ҮТЕГ тайландаа оруулж тайлагнаагүй.
- “Гацуурт” ХХК-иас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэл болон зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын сар бүрийн тайлангаас үзэхэд уг татварыг төлсөн дүнгээр бус ногдуулсан дүнгээр тайлагнасан байна.
- “Монполимет” ХХК нь анх тайлангаа ОУИТБС-ын ажлын албанд гаргаж ирүүлээгүй байсан ба нэгтгэлийн явцад тайлангаа гаргаж өгсөнөөр залруулагдсан.
- “Үүрт гоулд” ХХК нь уг татварыг бусад татварын илүү төлөлтөөс суутган тооцсоныг тайландаа тусгаагүй байна.

1.4 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар (ҮХЭХАТ)

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр мян.төг	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Үл хөдлөх эд хөрөнгийн татвар	(203,487)	225,192	18,225	3,480

ҮХЭХАТ-ын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Таван толгой”, “Монголын алт МАК”, “Шижир алт”, “Чинхуа МАК нарийн сухайт”, “Шанлун” зэрэг компаниуд нь анхны тайландаа уг татварыг илүү тайлагнасан.
- “Бороо гоулд” ХХК төлсөн татвараа дэлгэрэнгүй мэдээллээр ирүүлээд байхад ЗГ хүлээн авсан татварын дүнг тусгаагүй.

1.5 Онцгой албан татвар (шатах тослох материал импортолсон бол)

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр мян.төг	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Онцгой албан татвар (шатах тослох материал импортолсон бол)	807,210	-	807,210	(1)

Онцгой албан татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет”, “Эрэл”, “Жамп”, “Бэрлэг майнинг” зэрэг компаниуд нь уг татварыг гаалийн албан татварын дүнд оруулан тайлагнасан.

1.6 Автобензин, дизелийн түлшний албан татвар

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр мян.төг	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	(73,801)	-	(73,801)	-

Энэ төрлийн татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет”, “Петро чайна дачин тамсаг” зэрэг компаниуд нь уг татварыг гаалийн албан татварын дүнд оруулан тайлагнасан.

1.7 Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр мян.төг	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	(13,330)	36,152	17,477	5,345

Энэ төрлийн татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Шижир алт”, “Айвенхоу майнз монголия инк”, зэрэг компаниуд нь уг татварын төлөлтийг тайландаа дутуу тусгасан.
- “Эрэл” ХХК-ийн Дархан-Уул аймагт төлсөн татварыг ЗГ тайландаа тусгаагүй.

1.8 Мөнгөн дүнгээрх бусад татварууд (1)

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр
	мян.төг	Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Мөнгөн дүнгээрх бусад татварууд (1)	(6,729,772)	52	(6,729,720)	-

Энэ төрлийн татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- "Айвенхоу майнз монголия инк", "Петро чайна дачин тамсаг" зэрэг компаниуд нь анх ОУИТБСАА-д тайлагнах шаардлагагүй татвар, шимтгэлийг тайлагнасан байсан ба бид уг дүнг хасч залруулгыг хийсэн.
- "Чинхуа МАК нарийн сүхйт" ХХК нь Хятад талын хувьцаа эзэмшигчид олгосон ногдол ашгаас суутган авч татварт шилжүүлсэн татварын төлбөрийг тайлагнасан.

1.9 Мөнгөн дүнгээрх бусад татварууд (2)

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр
	мян.төг	Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Мөнгөн дүнгээрх бусад татварууд (1)	(6,729,772)	138	(72,534)	-

Мөнгөн төрлийн бусад татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- "Гоби коул энд энержи" ХХК нь анх тайландаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дүнг мөнгөн дүнгээрх бусад татвараар тайлагнасан.

2. Төлбөрүүд

Анхлан ирүүлсэн маягтууд дахь төлбөрүүд хэсгийн зөрүүнүүд болон нэгтгэлийн үр дүнд ЗГ-ын нэгж байгууллагууд, компаниудаас ирүүлсэн дүнд хийсэн залруулгуудыг дараахи байдлаар харуулав. Үүнд:

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр
	мян.төг	Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
2.1 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	12,063,450	(14,718,202)	(2,636,553)	(18,200)
2.2 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	(5,039,899)	227,219	(4,815,382)	2,702
2.3 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр /доллар/	5,792	6,800	12,598	(6)
2.4 Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2,373,021	476	2,373,496	(-)
2.5 Газрын төлбөр	(9,569,969)	889,486	(8,674,701)	(5,782)
2.6 Ус, рашаан ашигласны төлбөр	(239,229)	297,350	67,366	(9,246)
2.7 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	(41,975)	36,656	(5,169)	(150)
2.8 Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	(36,960)	551,936	544,402	(29,426)
2.9 Түгээмэл тархцатай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	(1,031,109)	1,030,269	(840)	-
2.10 Бусад	(54,333)	-	(37,485)	(16,848)
Нийт	(1,571,212)	(11,678,010)	(13,172,267)	(76,955)

2.1 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ("роялти төлбөр")

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр
	мян.төг	Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ("роялти төлбөр")	12,063,450	(14,718,202)	(2,636,553)	(18,200)

АМНАТ-ийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- ЗГ "Болд төмөр ерөө гол" ХХК-ийн 2007 оны 12 дугаар сард төлсөн төлбөрийг 2008 оны тайланд оруулж тусгасан. Мөн уг компани болон "Цайрт минерал" ХХК-ийн 2008 оны 12 дугаар сард компаниас төлсөн дүнг ЗГ тайландаа тусгаж тайлагнаагүй.
- "Бороо гоулд" ХХК-иас төлсөн төлбөрийг ЗГ анхны тайландаа тусгаагүй байсныг дэлгэрэнгүй мэдээллээр нэмж мэдээлсэн.
- "Таван толгой" ХХК нь анхны тайландаа татварт төлсөн дүнгээр бус зардалд тусгасан дүнгээр тайлагнасан.
- "Монолын алт МАК" ХХК-иас хүлээн авсан төлбөрийн дүнг ЗГ дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж ирүүлэхдээ орон нутагт төлсөн төлбөрийн дүнг давхардуулж тайлагнасан.

2.2 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр /төгрөг/

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр
	мян.төг	Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	(5,039,899)	227,219	(4,815,382)	2,702

- Энэ төлбөрийг Ашигт малтмалын газар ам.доллороор тайланд тусгаж, компаниуд төлсөн төлбөрөө тайландаа Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлэн тайлагнасныг залруулсан.

2.3 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр /ам.доллар/

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр
	мян.доллар	Засгийн газрын нэгж байгууллагууд мян.доллар	Компаниуд мян.доллар	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	5,792	6,800	12,598	(6)

- Энэ төлбөрийг АМГ доллороор тайлагнасан бол ихэнх компаниуд төгрөгөөр тайлагнасан.

2.4 Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр
	мян.төг	Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2,373,021	476	2,373,496	(-)

- “Энгүй тал” ХХК 2008 оны тайлангаа ОУИТБС-ын ажлын албанд гаргаж ирүүлээгүй ба энэ компаниас тайланг нэгтгэлийн явцад гаргуулан авсанаар залруулга хийгдсэн.

2.5 Газрын төлбөр

Үзүүлэлт	Анхны зөрүүнүүд, цэвэр	Залруулагдсан байдал		Шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр
	мян.төг	Засгийн газрын нэгж байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Газрын төлбөр	(9,569,969)	889,486	(8,674,701)	(5,782)

- “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь Орхон аймгийг усаар хангадаг учраас газрын төлбөрийг төсвийн байгууллагуудын хэрэглэсэн усны төлбөрт суутган тооцдог тул зөрүүг залруулсан.
- Дараах компаниудаас зарим аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын алба болон татварын газруудад төлсөн төлбөрүүдийг УТЕГ дараах компаниудтай холбоо бүхий анхны тайландаа оруулж тайлагнаагүй байна. Үүнд:

№	Компанийн нэр	Төлбөр хүлээн авсан байгууллага
